

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Аудиторын дүгнэлт

Бид Тэнгэр Даатгал ХХК (цаашид "Компани" гэх)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"-ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нелөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг (үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хувалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгүүд багтана) –ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид:



Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2025 оны 2 дугаар сарын 26

Ж.Чинзориг
У.НАРАНДЭЛГЭР
Аудитор

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

ТОВЧИЛСОН ҮГС

Санхүүгийн тайландаа товчилсон үгсийн дараах хэв маягийг ашигласан болно:

НББОУСЗ	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл
СТОУС	Санхүүгийн тайлагналийн олон улсын стандартууд
АОУС	Аудитын олон улсын стандартууд
МОҮН	Мөнгөн орлого үүсгэгч нэгж
ГНА	Гэрээний нийт ашиг
ХБЭА, ХБХОА	Хүлээгдэж буй эрсдлийн алдагдал, хүлээгдэж буй хөрөнгө оруулалтын алдагдал
ХХНА	Нэгж хувьцааны ашиг
БҮЦӨБДӨБ	Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайландаа бүртгэгдэх
БҮЦӨАА	Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайландаа бүртгэгдэх
Тод	Санхүүгийн тайланын тодруулгууд
БДО	Бусад дэлгэрэнгүй орлого
ХХА	Хураамжийн хуваарилалтын арга
УХӨТ	Учирсан хохиролын өр төлбөр
YXXӨТ	Үлдсэн хугацаанд хамаарах өр төлбөр
AYM	Алдагдал үүсэх магадлал

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

**2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

(Мянган төгрөгөөр)	Тод	2024	2023
Даатгалын орлого	6, 9	17,554,215	10,516,230
Даатгалын үйлчилгээний зардал	6, 9	(11,244,971)	(4,534,762)
Даатгалын үйлчилгээний үр дүн		6,309,244	5,981,468
Давхар даатгалын орлого / (хураамжийн төлөлт)		385,936	(39,353)
Давхар даатгалаас хүлээн авсан нөхөн төлбөр		1,481,987	171,351
Давхар даатгалын цэвэр үр дүн		1,867,923	131,998
Даатгалын үйлчилгээний цэвэр үр дүн	6	8,177,167	6,113,466
Хорогдуулсан ертгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн хүүний орлого	7	4,937,142	3,248,822
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайландаа бүртгэгдэх хөрөнгө оруулалтын цэвэр олз	7	1,817,093	349,090
Хорогдуулсан ертгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз	7	-	133,168
Санхүүгийн хөрөнгө, гэрээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтын өөлчлөлтөөс үүссэн олз, гарз (үнэ цэнийн бууралтын буцаалтыг оруулсан)	7	(376,481)	(5,193)
Цэвэр хөрөнгө оруулалтын орлого	7, 13	6,377,754	3,725,887
Бусад олз / (гарз)	10	203,680	333,121
Бусад үйл ажиллагааны зардал	8	(6,657,060)	(4,412,732)
Бусад санхүүгийн зардал		(12,140)	(16,599)
Татварын өмнөх ашиг		8,089,401	5,743,143
Орлогын албан татварын зардал	11	(923,645)	(585,670)
Тайлант жилийн цэвэр ашиг		7,165,756	5,157,473
Бусад дэлгэрэнгүй орлого / (алдагдал)	12	(141,900)	1,165,223
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		7,023,856	6,322,696

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	Тод	2024.12.31	2023.12.31
ХӨРӨНГӨ			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	13	97,918	212,117
Санхүүгийн хөрөнгө	14	47,457,224	30,078,974
Хорогдуулсан өртгөөр бүртгэх		37,162,874	27,015,498
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх		8,272,713	1,764,342
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх		2,021,637	1,299,134
Даатгалын гэрээний хөрөнгө	9	2,131,854	1,119,387
Давхар даатгалын гэрээний хөрөнгө	15	106,456	498,835
Авлага	16	107,598	43,195
Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо ба бусад хөрөнгө	17	316,214	257,392
Бараа материал	18	57,372	43,784
Үндсэн хөрөнгө	19	2,403,666	2,065,454
Ашиглах эрхтэй хөрөнгө	20.1	168,408	153,191
Биет бус хөрөнгө	21	47,813	55,782
Нийт хөрөнгө		52,894,523	34,528,111
ӨР ТӨЛБӨР			
Даатгалын гэрээний өр төлбөр	9	13,724,634	10,019,667
Давхар даатгалын гэрээний өр төлбөр	15	425,827	463,809
Дансны ба бусад өр төлбөр	22	1,027,894	833,795
Орлогын албан татварын өр төлбөр	11.4	127,790	144,337
Хойшлогдсон татварын өр төлбөр	11.3	183,533	29,475
Түрээсийн өр төлбөр	20.2	136,816	143,105
Нийт өр төлбөр		15,626,494	11,634,188
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувьцаат капитал	23	6,000,000	5,000,000
Нэмж төлөгдсөн капитал	23.1	6,480,250	130,000
Тусгай нөөц сан		1,388,027	1,388,027
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	19	1,122,806	1,122,806
Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	7	(99,483)	42,417
Хуримтлагдсан ашиг		22,376,429	15,210,673
Эздийн өмч		37,268,029	22,893,923
Нийт эздийн өмч ба өр төлбөр		52,894,523	34,528,111

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Тусгай нөөц сан*	Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	Хуримтлагдсан ашиг	Нийт
2023 оны 1 сарын 1-ээрх	5,000,000	130,000	1,388,027	-	-	10,053,200	16,571,227
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	42,417	1,122,806	5,157,473	6,322,696
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-
2023 оны 12 сарын 31-ээрх	5,000,000	130,000	1,388,027	42,417	1,122,806	15,210,673	22,893,923
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	(141,900)	-	7,165,756	7,023,856
Эздийн өмчийн өөрчлөлт	1,000,000	6,350,250	-	-	-	-	7,350,250
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-
2024 оны 12 сарын 31-ээрх	6,000,000	6,480,250	1,388,027	(99,483)	1,122,806	22,376,429	37,268,029

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

* Тусгай нөөц санг Санхүүгийн Зохицуулах Хорооны ("СЗХ") шаардлагад нийцүүлэн байгуулсан бөгөөд СЗХ-той зөвшилцсөний үндсэн дээр Компанийн хувьцаа эзэмшигчид олгох боломжтой.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

**2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

(Мянган төгрөгөөр)	Тод	2024	2023
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Татварын өмнөх ашиг		8,089,402	5,743,143
<i>Татварын өмнөх ашигийг цэвэр мөнгөн гүйлгээтэй тохируулах мөнгөн бус тохируулгууд:</i>			
Үндсэн хөрөнгийн элэгдэл	8	138,170	107,339
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	8	87,101	75,535
Биет бус хөрөнгийн хорогдол	8	7,969	7,969
Ханшийн бодит бус (олз) / гарз		2,569	(18,220)
Хүүний зардал		12,208	16,601
Үндсэн хөрөнгө данснаас хассан гарз	19	7,870	10,982
Авлагын үнэ цэнийн бууралт		10,871	19,521
Хүүний орлого		(4,937,142)	(3,381,990)
Ногдол ашгийн орлого		(18,015)	-
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх хөрөнгө оруулалтын цэвэр олз	7	(1,817,093)	(349,090)
Үндсэн хөрөнгийн борлуулалтаас олсон (олз) / гарз	10	(1,235)	(1,497)
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг		1,582,675	2,230,293
<i>Ажлын капиталын өөрчлөлт:</i>			
Авлагын бууралт/(өсөлт)		(1,405,917)	1,083,314
Урьдчилж төлсөн төлбөр, тооцооны өсөлт		(72,400)	(47,427)
Хойшлогдсон даатгалын орлогын шимтэлийн өсөлт / (бууралт)		(1,563,864)	(480,870)
Давхар даатгагчид ногдох даатгалын нөөц (өсөлт) / бууралт		(3,236,826)	(1,521,780)
Даатгалын нөөц сангийн (өсөлт) / бууралт		(6,173,538)	488,213
Дансны болон бусад өглөгийн өсөлт / (бууралт)		(10,814)	1,504,400
Үйл ажиллагаанаас олсон мөнгөн гүйлгээ		(10,880,684)	3,256,143
Төлсөн хүү		(12,208)	(16,601)
Төлсөн татвар		(940,192)	(387,920)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(11,833,084)	2,851,622
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА			
Үндсэн хөрөнгийн худалдан авалт		(93,129)	(237,035)
Түрээсийн сайжруулалтын нэмэгдэл зарцуулсан		(82,034)	-
Үндсэн хөрөнгө борлуулсаас олсон		2,012	1,649
Санхүүгийн хөрөнгө оруулалтад зарцуулсан		-	(6,441,913)
Хүлээн авсан хүүний орлого		4,668,273	3,634,784
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		4,495,122	(3,042,515)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Түрээсийн төлөлт		(123,918)	(87,578)
Нэмж хувьцаа гаргаснаас олсон		7,350,250	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		7,226,332	(87,578)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт / (бууралт)		(111,630)	(278,471)
Ханшийн зэрүүний нөлөө		(2,569)	18,220
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13	212,117	472,368
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13	97,918	212,117

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. Ерөнхий мэдээлэл

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь Монгол улсад ердийн даатгалын үйлчилгээ үзүүлэх юм. Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2007 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр олгосон 58 дугаар тогтоолын дагуу ердийн даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг. Компанийн үзүүлдэг даатгалын төрлүүдэд хөрөнгийн, тээврийн хэрэгслийн, гэнэтийн ослын, хариуцлагын болон бусад ердийн даатгалууд багтдаг.

Компанийн үндсэн үйл ажиллагаа явуулдаг албан хаяг нь "Сити Цэнтр", 11 давхар, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот-17062, Монгол улс болно. Компанийн улсын бүртгэлийн дугаар нь 9017001018 ба регистрийн дугаар нь 2648016. Компанийн хувьцаат капитал нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 60 сая ширхэг энгийн хувьцаанаас бурдэнэ. Тайлант хугацааны эцэст хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хэмжээ дараах байдалтай байна.

№	Хувьцаа эзэмшигчид	Регистрийн дугаар	Хувьцааны тоо	Эзэмшилийн хувь (%)	Нийт хувьцааны нэрлэсэн үнэ (мян.төг)
1	Мандал Прайвит Экүити Хувийн ХОС ХХК ("МПЭ")	6756093	17,500,000	29.17%	1,750,000
2	Мандал Санхүүгийн Нэгдэл ХХК	5435188	25,500,000	42.50%	2,550,000
3	Мандал Ассет Менежмент Секьюритис ХХК	5497418	2,250,000	3.75%	225,000
4	Мандал Капитал Маркетс Секьюритис ХХК	5213487	2,250,000	3.75%	225,000
5	Бусад*	-	12,500,000	20.83%	1,250,000
		Нийт	60,000,000	100.00%	6,000,000

*Санхүүгийн Зохицуулах Хорооны 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 413 тоот тогтоолоор Компанийг нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 60 сая энгийн хувьцаатай байхыг хүлээн зөвшөөрсөн. Мөн уг тогтоолоор Компанийг өөрийн 12,500,000 ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар ширхэг тус бүрийг 800 төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг зөвшөөрсөн. Дараах хүснэгт нь 2024 онд Компанийн нэмэлтээр энгийн хувьцаа олон нийтэд санал болгон худалдсантай холбогдох ажил гүйлгээний задаргааг харуулна.

	Хувьцааны үнэ	Хувьцааны тоо	Нийт үнэлгээ мян.төг
Хувьцаа эзэмшигчдээс эргэн худалдан авсан	800	(2,500,000)	(2,000,000)
Нэмэлтээр нийтэд зарлан, худалдсан	800	12,500,000	10,000,000
Хувьцаагаа анхдагч зах зээл дээр гаргасантай холбогдох шууд зардал	-	-	(649,750)
Нийт дүн		10,000,000	7,350,250

Хувьцаат капиталын нэмэгдэл	1,000,000
Нэмж телөгдсөн капиталын нэмэгдэл – Тодруулга 22.1	6,350,250

Санхүүгийн тайлангийн тайлагналын өдрийн байдлаар Компани нь Улсын Бүртгэлийн Байгууллага-д Хувьцаат компаниар бүртгүүлэхээр холбогдох материал, баримтадаа бэлтгэн ажиллаж байна.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Төлөөлөн Удирдах Зөвлөл

№	Гишүүд	Үүрэг, хариуцлага
1	Шаравпэлжээ овогтой Гантуяа	Дарга
2	Түмэннасан овогтой Батзул	Гишүүн
3	Ринчинням овогтой Амаржаргал	Хараат бус гишүүн
4	Цэвэгмид овогтой Түмэнцогт	Хараат бус гишүүн
5	Галзагд овогтой Туул	Хараат бус гишүүн
6	Балдан овогтой Энхтувшин	Нарийн бичгийн дарга

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолоор Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг баталж, нийтэд мэдээлэхийг зөвшөөрсөн болно.

2. **Үйл ажиллагааны орчин**

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбарт тулгуурласан хэвээр байгаа бөгөөд нүүрс, зэсийн экспорт эдийн засагт голлох нөлөө үзүүлж байна. 2023 онд эдийн засаг 7.0%-иар ессөн нь ашигт малтмалын экспорт нэмэгдэж, худалдааны баланст зөрэг нөлөө үзүүлсэнтэй холбоотой боловч инфляци, төгрөгийн ханшийн уналт, олон улсын зах зээлийн хэлбэлзэл нь эрсдэл дагуулсан хэвээр байна. Хууль, татвар, зохицуулалтын орчин тасралтгүй өөрчлөгдж байгаа нь бизнесийн үйл ажиллагаанд шууд нөлөөлж байна. 2024 оны эдийн засгийн өсөлтийн төлөв 4.1%-иас 7.5% хооронд хэлбэлзэж байгаа нь БНХАУ-ын эрэлт хэрэгцээ, дэлхийн түүхий эдийн үнэ, Монгол Улсын дотоод бодлогоос хамааралтай гэж үзэж байна.

Түүнчлэн дэлхийн эдийн засгийн тодорхойгүй байдал, эрэлт нийлүүлэлтийн доголдол, түүхий эдийн үнийн хэлбэлзэл, геополитикийн эрсдэлүүд зэрэг нь бизнесийн орчинд нөлөөлсөн хэвээр байна. ОХУ болон Украинаы дайн нь олон улсын худалдаа, эрчим хүчний зах зээлд нөлөөлсөөр байгаа бол Израиль-Газын мөргөлдөөн нь дэлхийн эдийн засагт, ялангуяа газрын тосны үнэд тодорхойгүй байдлыг бий болгож байна. Эдгээр хүчин зүйлс нь Монгол Улсын инфляци, санхүүгийн зах зээл, эдийн засгийн ерөнхий төлөвт нөлөөлж болзошгүй. Байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) асуудал бизнесийн орчинд улам бүр чухал байр суурь эзлэх боллоо. Монгол Улс эдийн засгийн олон талт хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд 2030 он гэхэд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30%-д хүргэх зорилт тавьж байгаа бөгөөд уул уурхайн салбарын компаниудад ил тод, тогтвортой үйл ажиллагаа явуулах шаардлага нэмэгдэж байна. Олон улсын хөрөнгө оруулагчдын хүлээлт, зохицуулалтын шинэ шаардлагуудын хүрээнд ESG-тэй уялдсан бизнесийн загварыг хэрэгжүүлэх нь зайлшгүй болж байна.

Удирдлага нь Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, ажилчдаа дэмжих чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч байна. Гэсэн хэдий ч өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлын ирээдүйн үр нөлөөг урьдчилан таамаглахад хэцүү бөгөөд удирдлагын одоогийн хүлээлт, тооцоолол нь бодит үр дүнгээс ялгаатай байж болно.

3. **Тайлан бэлтгэх үндэслэл**

3.1 **Нийцлийн мэдэгдэл**

Компанийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУС3")-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд ("СТОУС")-ын дагуу бэлтгэгдсэн. Санхүүгийн тайлан дахь санхүүгийн хэрэглүүрээс бусад тохиолдолд санхүүгийн тайланг түүхэн өргтийн үндсэн дээр бэлтгэсэн болно.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Энэхүү тайланг бэлтгэж, тайлагнахдаа Компанийн бүртгэлийн валют буюу Компанийн үйл ажиллагаа эрхэлж буй эдийн засгийн орчны үндсэн валют болох Монгол Улсын мөнгөн тэмдэгт Төгрөгөөр илэрхийлсэн. Тусгайлсан хэсэгт онцлон зааснаас бусдаар бүх дүнг мянгачилж (мянган төгрөгөөр эвсэл төг.мян) толилуулсан.

3.2 Тасралтгүй байх зарчим

Удирдлагын зохижжтой гэж үзсэний дагуу тасралтгүй байх зарчмын дагуу санхүүгийн тайланг бэлтгэсэн. Компанийн эргэлтийн хөрөнгө 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар 34,831,675 мянган төгрөгөөр богино хугацаат өр төлбөрөөсөө давсан ба тайлант жилийн цэвэр ашиг 7,165,756 мянган төгрөг байсан. Компани урт хугацаат зээлийн үлдэгдэлгүй болно.

3.3 Таамаглал, тооцоолол ба үнэлгээ хэрэглэх нь

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцуулэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нелөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зерүүтэй байж болно.

Компани санхүүгийн тайланг бэлтгэхдээ тухайн үеийн боломжит таамаглал, тооцоолол дээр сууринсан. Одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн таамаглал нь зах зээлийн өөрчлөлт эсвэл компанийн хяналтаас гадуурх үйл ажиллагаанаас хамаарч өөрчлөгдөж болзошгүй. Үүнтэй холбоотойгоор аливаа өөрчлөлтүүд тохиолдсон даруйдаа таамаглалын суурь болон тооцоололд тусгагддаг.

Дараа жилийн санхүүгийн тайланд материаллаг запруулга хийх эрсдэл учруулахуйц таамаглал болон тооцооллын тодорхой бус асуудлын талаарх мэдээллийг доор дурьдсан тодруулгын хэсэгт багтаасан.


3.3.1 Хойшлогдсон албан татвар

Компани нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг тооцоолохдоо Монгол Улсын хуулиар тогтоосон татварын хувь хэмжээ, татвараас хасагдахгүй зардлууд, татварын хуульд орсон өөрчлөлтүүд болон удирдлагын хүлээж буй ирээдүйн үр дүн зэргийг харгалзаж үздэг. Хойшлогдсон орлогын албан татварыг түр зөрүүн дээр сууринлан тооцоолдог ба энэ нь санхүүгийн тайландаа тайлант тайлагнасан орлого, зардал болон татварын хуулийн дагуу тодорхойлсон татвар ногдох орлого, зардлын хоорондох зөрүү юм. Эдгээр түр зөрүүнээс үүссэн татварын нелөөллийг санхүүгийн тайландаа хойшлогдсон татварын хөрөнгө эсвэл өр төлбөрөөр тусгадаг.

Компанийн удирдлага нь хойшлогдсон татварын хөрөнгө хэрэгжихгүй гэж үзэж байгаа тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрдөггүй. Бодит үр дүн нь энэ таамаглалаас зөрүүтэй байх тохиолдолд ирээдүйн тайлант жилүүдэд уг таамаглалын запруулга хийх ба тайлант жилийн санхүүгийн байдал болон орлогод материаллаг нелөө үзүүлэхүйц өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч хойшлогдсон татварын хөрөнгөөр бүртгэх шаардлага тулгарч болно.

3.3.2 Үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа

Компанийн удирдлага нь үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон холбогдох элэгдлийн зардлыг тооцоолдог. Энэхүү тооцооллыг ижил шинж чанар, үүрэгтэй хөрөнгийн бодит ашиглалтын хугацаанд сууринлан хийдэг. Энэ нь техник технологийн томоохон шинэчлэл, өрсөлдөгчдийн салбарын хөдөлгөөнд үзүүлж буй хариу үйлдлийн үр дүнд их хэмжээгээр өөрчлөгдөж болно. Удирдлага өнөөгийн тооцоолсон ашиглалтын хугацаа нь емнө нь тооцоолсон ашиглалтын хугацаанаас бага гэж үзвэл элэгдлийн зардлыг нэмэгдүүлж, эсвэл техник болон стратегийн хувьд хоцрогдсон, хаягдсан эсвэл борлуулсан хөрөнгийг данснаас хасаж эсвэл үнэ цэнийг бууруулдаг. Компанийн хөрөнгийн ашиглах хугацааг хэрхэн тодорхойлсныг Тодруулга 5.7-с харна уу.



ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3.3.3 Бодит үнэ цэнийн хэмжилт

Компани нь хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлоходо тухайн зах зээл дээрх хамгийн сайн ажиглагдахуйц мэдээллийг ашиглахыг зорьдог. Бодит үнэ цэнийг үнэлгээний арга барилд ашиглагдах өгөгдлүүдэд үндэслэн бодит үнэ цэнийн шатлалаар дараах түвшинд ангилдаг:

- Түвшин 1:** Ижил төстэй хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээлийн жишиг үнэ (тохируулагдаагүй).
- Түвшин 2:** Түвшин 1 дэх идэвхтэй зах зээл дээрх хөрөнгө, өр төлбөрийн жишиг үнээс бусад шууд (жишээлбэл: үнэ) болон шууд бусаар (жишээлбэл: үнээс хамааралтай) ажиглаж болох өгөгдлүүд.
- Түвшин 3:** Ажиглаж болох зах зээлийн өгөгдөл үндэслээгүй хөрөнгө, өр төлбөрийн өгөгдөл (ажиглаж болохооргүй өгөгдлүүд)

Хэрэв бодит үнэ цэнийн шатлалын түвшин хооронд шилжсэн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихэд олон төрлийн өгөгдөл ашигласан бол Компани хөрөнгө, өр төлбөрийг бүх хэмжсэн үнэ цэнэд нөлөөлөхуйц бодит үнэ цэнийн шатлалын дундах өгөгдлийн хамгийн бага түвшинд ангилах ба түвшин хоорондын шилжилтийг тухайн шилжилт хийгдсэн тайлант үеийн эцэст хүлээн зөвшөөрнө.

3.3.4 Мөнгөн гүйлгээний биелэлт – Энгийн болон давхар даатгалын гэрээнүүд

Мөнгөн гүйлгээний биелэлт дараахаас бүрдэнэ:

- Ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн тооцоолол;
- Ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцоонд санхүүгийн эрсдэлийг оруулаагүй тохиолдолд мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн гүйлгээтэй холбоотой санхүүгийн эрсдэлийг тусгах залруулга; мөн
- Санхүүгийн бус эрсдэлд эсрэлийн залруулга.

Ирээдүйн мөнгөн гүйлгээг тооцоолоходо Компанийн зорилго нь боломжит үр дүнг бүрэн тусгасан олон хувилбаруудын хүлээгдэж буй үнэ цэнийг тодорхойлох явдал юм. Ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцоолол нь ирээдүйн үйл явдлын өнөөгийн хүлээлтийг тусгахын тулд шинэчлэгдсэн нэхэмжлэлийн талаарх гадаад болон дотоод түүхэн мэдээлэл болон бусад туршлагыг харгалзан тайлант өдрийн өнөөгийн нехцэл байдлын талаарх Компанийн үзэл бодлыг тусгасан болно.

4. Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын өөрчлөлтүүд

4.1 Шинэ буюу шинэчилсэн стандарт болон тайлбар тодруулгуудын хэрэгжилт

Дараах нэмэлт, өөрчлөлт оруулсан стандартууд 2024 оны 1-р сарын 1-нээс хучин төгөлдөр болсон ба Компани нягтлан бodoх бүртгэлдээ мөрдөж эхэлсэн болно:

- СТОУС S1 Тогтвортой байдлын талаарх санхүүгийн мэдээллийн тодруулгад тавигдах шаардлага
- СТОУС S2 Уур амьсгалын тодруулга
- СТОУС 16 - нэмэлт өөрчлөлт Борлуулалт болон буцаан түрээслэх үеийн түрээсийн өр төлбөр
- НББОУС 1 - нэмэлт өөрчлөлт Өр төлбөрийн богино ба урт хугацааны ангилал
- НББОУС 1 - нэмэлт өөрчлөлт Богино хугацаат гэрээний өр төлбөр
- НББОУС 7 болон СТОУС 7 - нэмэлт өөрчлөлт Нийлүүлэгчийн санхүүжилтийн зохицуулалт

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Дээрх шинэ стандарт, стандартуудын өөрчлөлтүүд болон тайлбар нь Компанийн санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд томоохон нелөө үзүүлээгүй болно.

4.2 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд

Компанийн санхүүгийн тайлангуудыг баталж гаргах өдрийн байдлаар батлагдаж гарсан ба 2025 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхлэх стандартууд болон тайлбаруудын жагсаалтыг дор үзүүлэв. Компани энэхүү стандартуудыг шаардлагатай тохиолдолд хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс мөрдөх хандлагатай байна.

	Тайлбар	Гаргасан огноо	Мөрдөж эхлэх огноо
• НББОУС 21	Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нелөө	2025 оны 1 дүгээр сар	2025 оны 1 дүгээр сарын 1
Гол өөрчлөлт болон асуудлууд	Арилжааны дутмаг чанарын нэмэлт өөрчлөлт		
• СТОУС 7	Санхүүгийн хэрэгслүүд: Тодруулга	2024 оны 5 дугаар сар	2026 оны 1 дүгээр сарын 1
Гол өөрчлөлт болон асуудлууд	Санхүүгийн хэрэгслүүдийн ангилал, хэмжилттэй холбоотой нэмэлт өөрчлөлтүүд		
• СТОУС 9	Санхүүгийн хэрэгслүүд	2024 оны 5 дугаар сар	2026 оны 1 дүгээр сарын 1
Гол өөрчлөлт болон асуудлууд	Санхүүгийн хэрэгслүүдийн ангилал, хэмжилттэй холбоотой нэмэлт өөрчлөлтүүд		
• СТОУС 18	Санхүүгийн тайлангийн таницуулга ба тодруулга	2024 оны 4 дугаар сар	2027 оны 1 дүгээр сарын 1
Гол өөрчлөлт болон асуудлууд	СТОУС 18-д үндсэн агуулга нь ашиг, алдагдлын тайлангийн бүтэц "удирдлагын тодорхойлсон гүйцэтгэлийн хэмжүүр"-үүдтэй холбоотой санхүүгийн тайланда шаардлагатай тодруулгууд; мөн нэгтгэх, задлах зарчмуудыг илүү сайжруулсан		
• СТОУС 19	Нийтэд мэдээлдэггүй охин компаниудын санхүүгийн тайлангийн тодруулга	2024 оны 5 дугаар сар	2027 оны 1 дүгээр сарын 1
Гол өөрчлөлт болон асуудлууд	Шинэ стандарт нь холбогдох охин компаниудын санхүүгийн тайлангийн тодруулгад тавигдах шаардлагыг багасгасан		

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4.3 СТОУС 17 – Даатгалын гэрээ

2017 оны 5 сард НББОУСЗ нь даатгалын гэрээний хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, тайлагнал болон толилуулгын зарчмуудыг тусгасан нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн стандарт болох СТОУС 17 Даатгалын гэрээ стандартыг баталсан. СТОУС 17 хүчин төгөлдөр болох хугацаанаасаа эхлэн 2005 онд батлагдсан СТОУС 4 Даатгалын гэрээ стандартыг орлоно. СТОУС 17 нь даатгалыг гаргаж буй аж ахуйн нэгжийн төрлөөс үл хамааран бүх төрлийн (жишээлбэл амьдралын, ердийн, шууд даатгал болон давхар даатгал гэх мэт) мөн түүнчлэн тодорхой онцлог бүхий баталгаа болон санхүүгийн хэрэгслийг хамаарна.

Хамрах хүрээний хувьд цөөн хэдэн зүйлсийг үл хамаарна. СТОУС 17-ийн ерөнхий зорилго нь даатгалын гэрээний нягтлан бодох бүртгэлийн загварыг даатгагчид илүү ашигтай, тогтвортой байлгаж өгөх явдал юм. СТОУС 4-т тавигдах шаардлагаас ялгаатай нь СТОУС 17 нь нягтлан бодох бүртгэлийн холбогдох бүх талыг хамарсан даатгалын гэрээний цогц загварыг гаргаж өгсөн.

СТОУС 17-ийн гол цом нь ерөнхий загвар бөгөөд нэмэлтээр:

- Сонголттой оролцох шинж чанар бүхий гэрээнд тохирсон тодорхой тохируулга (хувьсах төлбөрийн хандлага)
- Богино хугацаат гэрээнд голчлон зориулсан хялбаршуулсан арга (шимтгэл хуваарилах арга)

СТОУС 17 нь 2023 оны 1 сарын 1 болон түүнээс хойш тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр болох ба харьцуулах мэдээллийн хамт толилуулах шаардлагатай.

Компани 2023 оны 1 сарын 1-ээс эхлэх тайлант жилд СТОУС 17 -г нягтлан бодох бүртгэлдээ нэвтрүүлсэн ба холбогдох бусад холбогдох нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудад өөрчлөлт оруулсан. СТОУС 17-д нийцүүлэн тайлагнахын хүрээнд харьцуулах мэдээ буюу 2022 оны дүнгүүдийг дахин тайлагнасан болно.

i. Даатгалын гэрээний хүлээн зөвшөөрөлт, хэмжилт болон толилуулга

СТОУС 17 нь даатгалын компанийн даатгалын гэрээ, давхар даатгал болон сонголттой оролцох шинж бүхий хөрөнгө оруулалтын гэрээний хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, толилуулга болон тодруулгын зарчмуудыг тогтоосон. Энэ нь Компани гэрээний мөнгөн урсгалыг таамаглах ба түүнд эрсдэлийн тохируулга хийж, хөнгөлөлт тооцож өнөөгийн үнэ цэнээр хэмжих загварыг танилцуулсан. Түүнчлэн хөрөнгө оруулалтын хэсэг нь даатгалын гэрээний орлого болон даатгалын үйлчилгээний зардлын хэсэгт оруулахгүй юм. Компани нь даатгалын гэрээтэй холбоотой хөрөнгө болон өр төлбөрийн далд бүртгэлийг хэрэглэж болохгүй.

Компани нь хураамжийн хялбаршуулсан арга ашиглах шаардлага хангаагүй даатгалын гэрээнээс бусад ердийн даатгалын гэрээний хэмжилтийг хураамжийн хялбаршуулсан аргыг (ХХА) ашиглан тооцсон. Хураамжийн хялбаршуулсан аргаар тооцсон үлдэх хугацааны өр төлбөрийг тооцоолол нь өмнөх нягтлан бодох бүртгэлийн аргатай ижил бөгөөд Компани нь үлдэх хугацааны өр төлбөрийг өмнөх нягтлан бодох бүртгэлийн аргыг ашиглах тооцоолсон. Харин үүссэн нөхөн төлбөрийн өр төлбөрийг хэмжихдээ Компани нь хүлээгдэж буй нөхөн төлбөрийн мөнгөн гүйлгээг (нөхөн төлбөрийн тохиолдолд үүссэн өдрөөс хойш нэг жил ба түүнээс богино хугацаанд бий болсон бол тооцоолоогүй болно) хорогдуулж, санхүүгийн бус эрсдэлийг тохируулан өнөөгийн үнэ цэнээр тооцсон болно. Өмнөх стандартаар даатгалын гэрээний шимтгэлийн зардлыг ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогод тусгаж, хойшлогдсон даатгалын гэрээний шимтгэлийн зардлыг хөрөнгө хэсэгт толилуулдаг байсан. СТОУС 17-н дагуу даатгалын гэрээг хүлээн зөвшөөрөхөөс өмнө үүссэн даатгалын гэрээний шимтгэлийн зардлыг мөнгөн урсгалын тооцоонд тусгаж, нөхөн сэргээгдэх эсэхийг шалгасны дараа хөрөнгөөр хүлээн зөвшөөрдөг.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Даатгалын гэрээний шимтгэлийн зардлыг холбогдох даатгалын гэрээний багцад хүлээн зөвшөөрөх ба даатгалын гэрээний хэрэгжилтийг даган зарлагадна.

Давхар даатгалын гэрээнээс үүссэн орлого болон зардлыг даатгалын гэрээнээс салгаж тусад нь цэвэршүүлсэн дүнгээр ашиг алдагдлыг тайландаа тусгасан. Өмнөх стандарттаар давхар даатгал руу шилжүүлсэн хураамжийн зардал болон давхар даатгалаас хүлээн авсан нехөн төлбөрийг тусад нь толилуулдаг байсан.

Даатгалын гэрээг багцлан ангилах

Компани даатгалын гэрээний багцыг тогтоох бөгөөд энэхүү багц нь ижил төсөөтэй эрсдэлд орох ба хамтад нь удирдах гэрээнүүдээс бүрдэнэ. Ижил төрлийн даатгалын бүтээгдэхүүнүүдийг нэг багцад ангилана.

Дээрх багцыг ангилахдаа:

- a) Хэрэв байгаа бол анх хүлээн зөвшөөрөх үед алдагдалтай гэрээнүүдийн бүлэг
- b) Хэрэв байгаа бол анх хүлээн зөвшөөрөх үед тэдгээр нь дараагийн тайлант үед алдагдалтай болох мэдэгдэхүй магадлалгүй гэрээнүүдийн бүлэг
- c) Хэрэв байгаа бол уг багцад үлдсэн гэрээнүүдийн бүлэг.

Хүлээн зөвшөөрөлт

Компани дараах хугацааны аль түрүүнд болох өдрөөс эхлэн өөрийн гаргасан даатгалын гэрээнүүдийн бүлгийг хүлээн зөвшөөрнө:

- a) Гэрээнүүдийн бүлгийн хамрах хугацааны эхлэл
- b) Тухайн бүлэг дэх даатгалын гэрээ эзэмшигчээс анхны төлбөрийг авах ёстой өдөр; ба
- c) Алдагдалтай гэрээнүүдийн бүлгийн хувьд, уг бүлэг нь алдагдалтай болсон өдөр.

Хураамжийн хуваарилалтын арга

Хураамжийн хуваарилалтын аргыг ашиглах үндэслэл:

- IFRS 17-ийн дагуу хүлээн зөвшөөрөлтийн хэмжилт нь Хураамжийн хуваарилалтын аргаас материаллаг хэмжээний зөрүүгүй байх хэмжилтийг тухайн бүлгийн даатгалын хамралтын үлдсэн хэсгийн өр төлбөрийн хувьд бий болгоно гэж компани ул үндэслэлтэй хүлээдэг;
- Компаний даатгалын гэрээний бүлэг дэх гэрээ тус бүрийн хамрах хугацаа нь нэг жил буюу түүнээс богино байх шалгуурыг хангадаг.

Компани хураамжийн хуваарилалтын хандлагыг ашиглахдаа даатгалын хамралтын үлдсэн хэсгийн өр төлбөрийг дараах байдлаар хэмждэг. Үүнд:

1. Анх хүлээн зөвшөөрөх үед уг төлбөрийн дансны үнэ нь дараах байдлаар тодорхойлогоно.
 - a. Хэрэв байгаа бол анх хүлээн зөвшөөрөхдөө хүлээн авсан хураамж
 - b. Үүнээс хасах нь: тухайн аж ахуйн нэгж нь даатгалыг худалдан авах мөнгөн гүйлгээ *
 - c. Нэмэх эсвэл хасах нь: тухайн өдөр дараах зүйлсийг үл хүлээн зөвшөөрснөөс үүссэн аливаа дүн:
 - i. Даатгалын худалдан авалтын мөнгөн гүйлгээний хувьд даатгалын бүлгийн гэрээнүүдийг хүлээн зөвшөөрөхийн өмнө төлсөн даатгалын хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн худалдан авалтын мөнгөн гүйлгээ
 - ii. Даатгалын гэрээтэй холбоотой өмнө нь хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, эсвэл өр төлбөр

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2. Дараагийн тайлант үе бүрийн эцэс дэх уг өр төлбөрийн дансны үнэ нь тухайн тайлант үеийн эхэн дэх дансны үнэд доорх тохируулгыг хийсэн дүн байна.
- Тухайн тайлант үед авсан хураамж
 - Үүнээс хасах нь: тухайн аж ахуйн нэгж нь даатгалыг худалдан авах мөнгөн гүйлгээ
 - Аж ахуйн нэгж нь даатгалын худалдан авалтын мөнгөн гүйлгээг гарсан даруйд зардал гэж хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд тухайн тайлант үед зардал гэж хүлээн зөвшөөрсөн, уг даатгалын мөнгөн гүйлгээний хорогдуулгатай холбоотой аливаа дүн,
 - Нэмэх нь: Санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсэгт хийсэн аливаа тохируулга
 - Хасах нь: Тухайн тайлант үед үзүүлсэн даатгалын хамааралтын хувьд даатгалын орлого гэж хүлээн зөвшөөрсөн дүн
 - Хасах нь: Учирсан хохирлын өр төлбөрийн хувьд төлсөн буюу шилжүүлсэн аливаа хөрөнгө оруулалтын бүрэлдэхүүн хэсэг.

Толилуулга

Компани дараах зүйлсийн бүлгүүдийн дансны үнийг санхүүгийн байдлын тайлант тус тусад нь толилуулна. Үүнд:

- Гаргасан бөгөөд хөрөнгө болох даатгалын гэрээнүүд;
- Гаргасан бөгөөд өр төлбөр болох даатгалын гэрээнүүд.

Эзэмшиж буй давхар даатгалын гэрээ

Хүлээн зөвшөөрөлт

Компани эзэмшиж буй давхар даатгалын гэрээнүүдийн бүлгийг дараах өдрүүдийн аль түрүүнд байх өдрөөс эхлэн хүлээн зөвшөөрнө:

- Эзэмшиж буй давхар даатгалын гэрээнүүдийн бүлгийн хамрах хугацааны эхэнд;
- Хэрэв компани уг өдөр эсвэл түүнээс өмнө эзэмшиж буй давхар даатгалын гэрээнүүдийн бүлэгт эзэмшиж байгаа холбогдох давхар даатгалын гэрээ байгуулсан бол суурь даатгалын гэрээнүүдийн алдагдалтай бүлгийг хүлээн зөвшөөрсөн өдөр.

Хэмжилт - Хураамжийн хуваарилалтын хандлага

Хураамжийн хуваарилалтын хандлагын аргын дагуу эзэмшиж буй давхар даатгалын гэрээнүүдийн бүлгийг хэмжихдээ гэрээт үйлчилгээний нийт ашгийг тохируулах бус харин даатгалын хамралтын үлдсэн хэсэг дэх хөрөнгийн дансны үнийг тохируулдаг.

Толилуулга

Компани дараах зүйлсийн бүлгүүдийн дансны үнийг санхүүгийн байдлын тайлант тус тусад нь толилуулна. Үүнд:

- Эзэмшиж буй бөгөөд хөрөнгө болох давхар даатгалын гэрээнүүд;
- Эзэмшиж буй бөгөөд өр төлбөр болох давхар даатгалын гэрээнүүд.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

ii. Шилжилт

СТОУС 17-н хэрэгжүүлэлтээс үүссэн нягтлан бodoх бүртгэлийн бодлогод гарсан өөрчлөлтүүдийг бүрэн шилжилтийн аргыг ашиглах хэрэгжүүлсэн. 2022 оны 1-р сарын 1-ний байдлаар Компани нь бүрэн шилжилтийн аргын хандлагын дагуу:

- СТОУС 17-г өмнө нь мөрдөж байсан шиг даатгалын гэрээ болон давхар даатгалын гэрээний бүлэг бүрийг тодорхойлж, хүлээн зөвшөөрч хэмжсэн;
- 2022 оны 1-р сарын 1-нээс өмнөх үнэлгээг хийгээгүйгээс бусад тохиолдолд СТОУС 17-г мөрдөж байсан мэт даатгалын гэрээний шимтгэлийн зардлыг мөнгөн гүйлгээнд зориулсан хөрөнгийг тодорхойлж, хүлээн зөвшөөрч хэмжсэн.

5. Нягтлан бodoх бүртгэлийн гол бодлогуудын товchoo

5.1 Орлого хүлээн зөвшөөрөлт

5.1.1 Даатгалын хураамжийн орлого ба шимтгэлийн орлого

Орлогын эдийн засгийн үр өгөөж нь Компанид орох нь тодорхой бөгөөд найдвартай хэмжих боломжтой болсон үед дараах үндэслэлээр хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Компанид эрсдэл шилжсэн үед даатгалын хураамжийг орлогоор хүлээн зөвшөөрнө.
- Шимтгэлийн орлогыг хүлээн авах магадлалтай болсон үед тухайн орлогыг хүлээн зөвшөөрнө.

Орлогод тооцоогүй хураамж нь гэрээний эрсдэл нь тайлагналын өдрийн дараа ч үргэлжилж байх хугацаанд ногдох гэрээний хураамжийн хэсэг юм. Орлогод тооцоогүй хураамж нь даатгалын гэрээ тус бүрийн тайлагналын өдрийн дараа ч үргэлжилж байх хугацаанд байгуулагдана. Тайлагналын өдрөөр даатгалын гэрээний хүчинтэй үлдэх хугацаанд хувь тэнцүүлэн тооцсон даатгалын хураамжийн хэсгүүдийн нийлбэрээр орлогод тооцоогүй хураамж болж хойшлодоно.

5.1.2 Хүүний орлого

Эдийн засгийн өгөөж нь Компанид ирэх өндөр магадлалтай ба орлогын дүнг найдвартайгаар тооцоолох боломжтой тохиолдолд хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрнө. Хүүг хугацаанаас хамааран үндсэн өрийг бодит хүүгийн хувиар үржүүлж хуримтлуулан бүртгэдэг. Бодит хүүгийн хувь гэдэг нь санхүүгийн өрийн хорогдуулсан өргтийг бodoх ба хүү тооцох хугацааны турш бүртгэх хүүгийн зардлыг хуваарилах арга юм.

Бодит хүүгийн хувь нь ирээдүйд хүлээн авахаар тооцоолсон бүх мөнгөн төлбөрийг тухайн санхүүгийн хэрэгслийн гэрээний хугацааны туршид хуваарилахад хугацааны эцэс гэхэд энх бүртгэсэн дансны цэвэр дүнтэй яг тэнцүү дүн үлдсэн байхаар хорогдуулдаг хүүгийн хувь юм.

5.1.3 Давхар даатгагчид ноогдох даатгалын хураамж

Давхар даатгагчид ногдох даатгалын хураамжийг гэрээ эхлэх хугацаа эсвэл даатгалын хураамжийн орлоготой холбоотойгоор давхар даатгагчид өглөг үүсгэх үеүйдийн аль эхэнд нь зардлаар хүлээн зөвшөөрнө. Давхар даатгагчид ногдох нийт даатгалын хураамжид гэрээнд заасан хугацаагаар даатгалын гэрээний өглөг багтдаг ба гэрээний эхлэх үед анхлан хүлээн зөвшөөрдөг.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Хураамжийн орлого нь өмнөх тайлант хугацаанд бүртгэсэн давхар даатгалын гэрээнүүдтэй холбоотой тайлант жилд мэдэгдсэн залруулгуудыг багтаана.

Давхар даатгагчид ногдох орлогод тооцоогүй хураамж гэдэг нь гэрээний эрсдэл нь тайлагналын өдрийн дараа ч үргэлжилж байх хугацаанд ногдох гэрээний хураамжийн хэсэг юм. Давхар даатгагчид ногдох орлогод тооцоогүй хураамж нь холбогдох эрсдэлийн хүрээнд үндсэн даатгалын гэрээний хугацаагаар буюу давхар даатгалын гэрээний хугацааны турш хойшлогддог.

5.2 Даатгалын зардал

Нөхөн төлбөрийн зардал

Нөхөн төлбөрийн зардалд бүх тайлант жилд гарсан нөхөн төлбөрүүд, эдгээртэй холбоотой дотоод болон гадаад нөхөн төлбөрийг барагдуулах үйл явц болон нөхөн төлбөрийг шийдвэрлэхтэй шууд хамааралтай зардлууд, үлдэх өртөг болон бусад буцаан авалтын хасагдуулга, мөн өмнөх жилээс төлөгдөөгүй үлдсэн нөхөн төлбөрүүдийн залруулгууд багтана.

Давхар даатгагчид ноогдох нөхөн төлбөр

Даатгалын нөхөн төлбөрийг тухайн даатгалын гэрээний нөхцелийн дагуу хүлээн зөвшөөрсөн үед давхар Даатгагчид ногдох төлбөрийг мөн адил хүлээн зөвшөөрнө.

5.3 Гадаад валютын хөрвүүлэлт

Компанийн үйл ажиллагааны валют нь Монгол төгрөг бөгөөд санхүүгийн тайлангууд нь төгрөгөөр тайлагнагдсан. Гадаад валютаар хийсэн гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийсэн өдрийн ханшийн түвшинд хөрвүүлэн үйл ажиллагааны валютаар бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө, төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг. Мөнгөн зүйлсийн төлөгдсөн буюу хүлээн авсан эсвэл хөрвүүлснээс үүссэн бүх зөрүүг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ. Өөрийн өртөг нь түүхэн өртгөөр хэмжигдэх мөнгөн бус зүйлийг анхны гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлэх бол бодит үнэ цэнээр хэмжигдэх мөнгөн бус зүйлийг бодит үнэ цэнэ тодорхой болсон өдрийн ханшаар хөрвүүлнэ. Мөнгөн бус зүйлсийн дахин хөрвүүлгээс үүссэн олз ба гарз нь тухайн зүйлийн бодит үнэ цэнийн олз, гарзтай адилаар бүртгэгдэнэ.

2024 оны 12 сарын 31-ний байдлаар гадаад валютын үлдэгдлийг хөрвүүлэхэд ашигласан ханш 1 ам.доллар = 3,420.25 төгрөг, 1 евро = 3,566.98 төгрөг байв. (2023 онд 1 ам.доллар = 3,410.69 төгрөг, 1 евро = 3,791.66 төгрөг байв).

5.4 Ажиллагсдын тэтгэмж

5.4.1 Богино хугацааны тэтгэмж

Цалин хөлс болон түүнтэй холбогдох бусад зардлуудыг Компанийн ажилтнуудаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалzan олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5.4.2 Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Монгол улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлне. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь ашиг, алдагдлын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

5.5 Холбоотой талуудын ажил гүйлгээ

Компани болон Компанийн толгой компани болон түүнтэй холбоотой этгээдүүдийн хооронд нөөц, ажил үйлчилгээ эсвэл үүрэг хариуцлага шилжүүлэхдээ телбөр нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд хийгдсэн ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ. Аливаа хувь хүн эсвэл түүний гэр булийн ойр дотнын гишүүнийг дараах тохиолдолд Компанитай холбоотой гэж үзнэ:

- Компанийг шууд эсвэл хамтран хянадаг;
- Компанийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг;
- Компанийн болон Компанийн толгой компанийн удирдах ажилтан.

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгжийг Компанитай холбоотой гэж үзнэ:

- Тухайн аж ахуйн нэгж болон Компани нь нэг бүлэг аж ахуйн нэгжийн бүрэлдэхүүнд багтаж байвал өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанийн багтдаг охин компаниуд бүгд бусадтайгаа холбоотой гэсэн үг юм;
- Нэг аж ахуйн нэгж нь негөө аж ахуйн нэгжийн хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол эсвэл негөө аж ахуйн нэгжийг багтаасан бүлгийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол;
- Хоёр компани хоёулаа нэг гуравдагч этгээдийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол;
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан үйлдвэр ба харин негөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч аж ахуй нэгжийн хараат компани бол;
- Тухайн аж ахуйн нэгж нь дээр дурдсан холбоотой талаар тодорхойлогдсон хувь хүний шууд эсвэл хамтарсан хяналтад байх; болон
- Компанийг шууд эсвэл хамтран хянадаг этгээд нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөөтэй байх, тухайн аж ахуйн нэгжийн, эсвэл түүний толгой компанийн удирдах ажилтан.

5.6 Орлогын албан татвар

5.6.1 Тайлант хугацааны орлогын албан татвар

Компани нь Монгол Улсын Засгийн газрын журмын дагуу орлогын албан татварын зориулалтаар тооцогдохгүй, хасагдахгүй орлогыг тохируулан санхүүгийн тайлангийн зорилгоор орлогод үндэслэн тайлант хугацааны албан татварыг ногдуулдаг. Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварын хөрөнгө ба ер төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь үйл ажиллагаа эрхэлж буй орны санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан.

5.6.2 Хойшлуулсан орлогын албан татвар

Хойшлуулсан орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаар хөрөнгө, ер төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хооронд түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Хойшлогдсон татварын өр төлбөр нь түр зөрүүд хүлээн зөвшөөрөгдөнө. Хойшлогдсон албан татварын хөрөнгийг татвар ногдох орлогоос хасагдах бүх түр зөрүүнүүд, ирээдүйд шилжүүлэн тооцох, ашиглаагүй татварын бүх хөнгөлөлт ба алдагдуудад (эдгээр түр зөрүү, хөнгөлөлт, алдагдуудыг хасаж болох татвар ногдох орлогын ирээдүйд орж ирэх нь тодорхой болсон үед) хүлээн зөвшөөрнө.

Хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна. Үл хүлээн зөвшөөрсөн хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр дахин үнэлж үздэг ба хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийг олж авах эсвэл өр төлбөрийг барагдуулах тэр тайлант хугацаанд хэрэглэгдэнэ гэж хүлээж байгаа (тайлант жилийн эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын хувь хэмжээ, татварын хуулиуд дээр үндэслэн) татварын хувь хэмжээгээр хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжинэ.

Нэг татвар телөгч, нэг татварын байгууллагад хамаарах хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэр дүнгээр тайлагнах хуулиар олгогдсон эрхтэй бол хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнаж болно.

5.7 Үндсэн хөрөнгө

Барилгаас бусад үндсэн хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр илэрхийлдэг. Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан тохиолдолд л тухайн үндсэн хөрөнгийн сольсон хэсгийн өртгийг тухай бүрд нь энэ өртөгт оруулна. Үндсэн хөрөнгийг дараах ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргыг ашиглан элэгдүүлнэ:

Хөрөнгө	Ашиглалтын хугацаа
Барилга	40 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	3 жил
Тавилга, эд хогшил	10 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Түрээсийн сайжруулалт	Түрээсийн хугацаа

Үндсэн хөрөнгө ба түүний томоохон хэсгүүдийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед данснаас хасна. Үүнтэй холбоотойгоор үүссэн аливаа нэг олз, гарзыг (хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) тухайн тайлант жилийн ашиг, алдагдлын тайландаа тусгана.

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр ашигийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцсэйнээр бүрд хянаж үздэг.

Барилгыг дахин үнэлгээний аргаар бүртгэдэг. Дахин үнэлгээний загварын аргыг хэрэглэж байх үед үнэлгээг тогтмол хийх ба ингэснээр тухайн хөрөнгийн үнэлгээ нь тайлант жилийн эцсээрх бодит үнэ цэнээсээ хэт зөрөхгүй байхыг шаарддаг.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Дахин үнэлгээний загварын аргаар бүртгэж буй хөрөнгөтэй нэг ангилалд хамаарах хөрөнгүүдийг мөн адил дахин үнэлгээний аргаар бүртгэх ёстой.

Дахин үнэлгээний загварын аргын үед хөрөнгийн элэгдэл тооцох арга нь өртгийн аргатай ижил байдаг.

Дахин үнэлгээгээр хөрөнгө нь үнэ цэнийн өсөлттэй байх тохиолдолд үнэ цэнийн өсөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч, эздийн өмчийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц дансанд бүртгэнэ. Харин хөрөнгө нь бодит үнэ цэнийн бууралттай байх үед дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц дансыг бууруулах, үлдэгдэлгүй тохиолдолд ашиг, алдагдлын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Дахин үнэлгээний аргаар бүртгэж байсан хөрөнгийг зарж борлуулах тохиолдолд тухайн хөрөнгөтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн үлдэгдлийг хуримтлагдсан ашиг руу хаах, эвсэл дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц дансанд үлдээж болно. Аль ч тохиолдолд зарж борлуулсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн үлдэгдлийг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрөхгүй болно.

5.8 Түрээс

Компани гэрээ байгуулах үед энэ нь түрээсийн гэрээ мөн эсэхийг үнэлнэ. Өөрөөр хэлбэл, хэрвээ гэрээ нь тодорхойлсон аливаа нэг хөрөнгийг тодорхой хугацааны турш ашиглах, хянах эрхийг шилжүүлж байгаа бол түрээсийн гэрээ гэж үзнэ.

Компани түрээслэгч үед

Компани богино хугацаат түрээс болон бага үнэ цэнэ бүхий хөрөнгийн түрээнсээс бусад бүх түрээсийн хүлээн зөвшөөрөлт болон хэмжилтийн нэг аргыг хэрэглэнэ. Компани түрээсийн төлбөрийг төлөөлж "түрээсийн ор төлбөр"-ийг хүлээн зөвшөөрч, тодорхойлсон хөрөнгийг түрээслэн ашиглах эрхийг төлөөлж "ashiглах эрхтэй хөрөнгө"-ийг хүлээн зөвшөөрнө.


5.8.1 Ашиглах эрхтэй хөрөнгө

Компани ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн эхлэх өдөр (хөрөнгийг ашиглаж эхлэх боломжтой болсон өдөр) эхлэн хүлээн зөвшөөрнө. Ашиглах эрхтэй Хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, аливаа үнэ цэнийн бууралтын алдагдлыг хасаж өртгөөр нь хэмжих бөгөөд түрээсийн өр төлбөрийг дахин үнэлэхэд тохируулна. Ашиглах эрхтэй хөрөнгийг өртөгт хүлээн зөвшөөрөгдсөн түрээсийн өр төлбөр, анхны шууд өртөг, түрээсийн урамшууллыг хүлээн авахаас өмнө буюу өмнөх өдрөөс эхлэн хийсэн түрээсийн төлбөрүүд багтана. Ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

Түрээс эхэлсний дараа, ашиглах эрхтэй хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын зардлыг хасаж, түрээсийн өр төлбөрийг дахин тооцоолоход тохируулсан ашиглалтын өртөг буюу үнэлгээгээр хэмжинэ.

5.8.2 Түрээсийн өр төлбөр

Компани түрээсийн хугацааны туршид төлөх төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнээр хэмжсэн түрээсийн өр төлбөрийг түрээс эхлэх өдөр хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөр гэдэгт аливаа урамшуулал хөнгөлөлтийг хассан түрээсийн тогтмол төлбөрөөс гадна хувь хэмжээнээс хамаарах хувьсах шинжтэй төлбөр, үлдэгдэл үнийн баталгааны дагуу төлөхөөр хүлээгдэж буй төлбөрүүдийг хамруулан авч үзнэ. Хувьсах шинжтэй түрээсийн төлбөр нь ямар нэг индекс, хувь хэмжээнээс хамааралгүй (бараа материал үйлдвэрлэхэд зориулж гаргаагүй бол) бол түүнийг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө.



ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Компани түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцох үед нуугдмал хүүгийн түвшинг тодорхойлох боломжгүй тохиолдолд урт хугацаат зээлийн хүүг ашиглана. Түрээс эхэлснээс хойш түрээсийн өр төлбөрийг хүүгийн зардлаар нэмэгдүүлж, төлсөн түрээсийн төлбөрийн дүнгээр бууруулна. Мөн түрээсийн өр төлбөрийн дансны үнийг түрээсийн гэрээний хугацаа, төлбөрийн дунг өөрчлөх, эсвэл үндсэн хөрөнгийн худалдан авах сонголтыг үнэлэхэд өөрчлөлт гарах үед дахин хэмжих шаардлагатай.

5.9 Биет бус хөрөнгө

Ашиглагдах жил нь тодорхой, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өргтөөс нь хуримтлагдсан элэгдэл ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжсэн. Биет бус хөрөнгийн хорогдуулгыг шулуун шугамын аргаар, биет бус хөрөнгийн ашиглалтын жилээр тооцоолсон. Тооцоолсон ашиглалтын жил болон элэгдэл бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг. Ашиглагдах жил нь тодорхойгүй, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өргтөөс нь үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжсэн.

Биет бус хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл үндсэн хөрөнгийн зүйлийг бүртгэлээс хасдаг. Биет бус хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд тусгана.

5.10 Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант үеийн эцэст санхүүгийн бус хөрөнгийн дансны үнийг үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илэрсэн эсэхийг тооцоолж үзнэ. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол үнэ цэнэ бууралтын алдагдал (ийм алдагдал гарсан бол)-ыг тогтоохын тулд тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно. Хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тухайн хөрөнгийн хувьд тооцоолох боломжгүй бол уг хөрөнгийн харьяалагдах мөнгөн орлого үүсгэгч нэгжийн нөхөгдөх боломжтой үнийг тооцоолно. Мөнгөн орлого үүсгэгч нэгжид хуваарилах боломжийн бөгөөд тууштай суурь үзүүлэлтийг тодорхойлж чадвал аж ахуйн зориулалттай хөрөнгийг тодорхой мөнгөн орлого үүсгэгч нэгжид хуваарилах ба ийм боломжгүй бол хамгийн боломжийн бөгөөд тууштай ашиглах боломжтой суурь үзүүлэлтийг ашиглан хамгийн жижиг мөнгөн орлого үүсгэгч нэгжид хамааруулан шалгадаг.

Хөрөнгийн эсвэл мөнгөн орлого үүсгэгч нэгжийн нөхөгдөх боломжтой үнэ гэдэг нь хөрөнгийн бодит үнээс борлуулах өртөг зардлыг хассан цэвэр дүн ба хөрөнгийг ашигласнаар олж болох өгөөж хоёрын аль ихээр нь тогтоогдоно. Ашигласнаар олж болох өгөөжийг үнэлэхдээ татварын өмнөх дискаунтын хувиар хорогдуулан тооцсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг ашигладаг. Дискаунтын хувь нь мөнгений цаг хугацааны үнэ цэнэ болон тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэлийн одоогийн зах зээлийн үнэлэмжийг тусгасан байх ёстой. Үнэ цэнэ бууралтын шалгалтын зорилгоор дангаар нь шалгах боломжгүй хөрөнгийг цаашид ашиглалтаар бусад хөрөнгө эсвэл бүлэг хөрөнгөөс (мөнгөн орлого үүсгэгч нэгж) хамааралгүйгээр дангаараа мөнгөн орлого бий болгох чадвартай хамгийн жижиг хөрөнгийн бүлэгт хамааруулан шалгадаг.

5.11 Санхүүгийн хөрөнгө

Хөрөнгө худалдан авсан зорилгоос хамаарч компани санхүүгийн хөрөнгийг доор дурдсан төрлүүдийн нэгээр нь ангилдаг.

(i) Санхүүгийн хөрөнгө – Бизнес загвар



ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Компани нь мөнгөн урсгалыг бий болгохын тулд хөрөнгийг хэрхэн удирддаг болохыг бизнесийн загвар харуулдаг. Компанийн нь бизнес загварын дараах зорилтуудаас сонголт хийж ашигладаг.

- Зөвхөн хөрөнгийн гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах
- Хөрөнгийг борлуулснаас үүсэх мөнгөн гүйлгээ эсвэл гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах
- Эсвэл дээрх 2 ангиллын алинд ч багтахгүй бусад загвар

(ii) Санхүүгийн хөрөнгө – Мөнгөн урсгалын онцлог

Бизнес загвар нь хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших авах эсвэл хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авах зорилготой үед мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй эсэхэд үнэлгээ өгнө. Энэ үнэлгээг хийхдээ гэрээний мөнгөн урсгал нь зээлийн гэрээний үндсэн тохиролцоонд нийцтэй эсэх, ялангуяа хүү нь зээлийн эрсдэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон зээлийн бусад эрсдэл, ашгийн түвшинг багтаасан эсэхийг авч үздэг.

Хейджийн харилцааны шаардлага хангасан санхүүгийн хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгийг компани дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу ангилна:

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөд мөнгөөр төлөгдөх үүсмэл хэрэглүүр болон цаг хугацааны үнэ цэний нөлөөгөөр цэвэрлэгдэж сөрөг болсон мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүр багтана (өр төлбөрөөр ангилагдсан мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүрийн тухай “Санхүүгийн өр төлбөр” хэсгээс харна уу).

Энэхүү ангилалд багтсан санхүүгийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэний өөрчлөлтийг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн санхүүгийн орлого эсвэл зардлын мөрөнд тусгана. Хейжийн хэрэглүүрийн зориулалтгүй үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусдаар компанийд арилжаалах зорилготой санхүүгийн хөрөнгө байхгүй бөгөөд компани санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг сайн дураараа ашиг, алдагдлаар хэмжигдэх ангилалд оруулдаггүй байна.

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх

Эдгээр хөрөнгө нь харилцагчид хүргэх бараа болон үйлчилгээний нөөцөөс (харилцагчдад олгосон зээл гэх мэт) ихэвчлэн үүсдэг. Гэхдээ мөн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд гэрээний мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрөөс бүрддэг бусад төрлийн санхүүгийн хөрөнгөөс үүсдэг. Эдгээрийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнэ дээр тэдгээрийг олж авах эсвэл гаргахтай холбоотой шууд хамааралтай гарсан ажил гүйлгээний зардлыг нэмж бүртгэх ба дараа үед үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон үнэ цэний бууралтыг хассан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Санхүүгийн хэрэглүүрийдиг анх хүлээн зөвшөөрсөн дунгээс аливаа үндсэн дүнгийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэний бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон гүйлгээний зардлын хорогдуулалт, хийж үр ашигт хүүгийн түвшингээр тооцно.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх

Компани нь охин компани, хараат компани эсвэл хамтын хяналттай аж ахуйн нэгжид багтаагүй, арилжаалах зорилгоор эзэмшдэггүй, хувьцаат болон хувьцаат бус аж ахуйн нэгж дэх стратегийн зорилго бүхий хөрөнгө оруулалт эзэмшиж байгаа тохиолдолд бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх хөрөнгө оруулалтаар ангилна. Эдгээрийг бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд бодит үнэ цэний өөрчлөлтийг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч буртгэх ба бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх нөөцийн үлдэгдлийг данснаас хасах замаар ашиг, алдагдал руу ангилахгүй ба харин шууд хуримтлагдсан ашиг руу ангилна.

Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах

Компани нь санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хугацаа дууссан, эсвэл санхүүгийн хөрөнгө шилжүүлсэн, хөрөнгийг эзэмшихтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг бусдад шилжүүлсэн бол санхүүгийн хөрөнгийг данснаас хасна. Хэрвээ Компани нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлээгүй боловч санхүүгийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг хадгалж үлдээгүй бол уг хөрөнгөөс Компанид үлдсэн хувь хэмжээгээр хөрөнгийг бүртгэлдээ хэвээрээ үлдээх ба төлбөр төлөх үүрэг байгаа бол холбогдох өрийг бүртгэнэ. Хэрвээ Компани нь шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийн ихэнхийг өөртөө хадгалсаар байгаа бол санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасахгүй ба санхүүгийн хөрөнгөөр барьцаалсан зээлийн өрийг бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь данснаас хасахаас бусад үед (жишээ нь Компани шилжүүлсэн хөрөнгийнхөө зарим хэсгийг буцаан худалдаж авах сонголт байгаа үед) Компани санхүүгийн хөрөнгийн дансны үнийг цаашдын оролцоо нь хэвээр хадгалагдах хэсэг болон цаашид хүлээн зөвшөөрөх боломжгүй хэсгүүдэд санхүүгийн хэрэгслийг шилжүүлэх өдрийн хэсэг тус бүрийн бодит үнэ цэнэд үндэслэн хуваарилна. Бүртгэлээс хассан хэсэгт хуваарилагдсан дансны үнээс түүний төлбөрт хүлээн авсан мөнгө ба бүртгэлээс хассан хэсэгтэй холбоотойгоор бусад иж бүрэн орлогоор тусгасан нийт олз гарзын нийлбэрийг хасаад гарсан зөрүүг ашиг алдагдалд тусгана. Бусад иж бүрэн орлогоор тусгасан нийт олз гарзыг бүртгэлд үлдээх хэсэг болон бүртгэлээс хасах хэсэгт тухайн хэсгүүдийн бодит үнэ цэнэд үндэслэн хуваарилна.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хэрэгслээс бусад санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнэ буурсан эсэхийг тайлант өдрөөр тодорхойлдог. Санхүүгийн хөрөнгийг анх бүртгэлд тусгаснаас хойш тохиолдсон нэг ба хэд хэдэн үйл явдал нь хөрөнгө оруулалтын ирээдүйн мөнгөн гүйлгээнд нөлөөлсөн гэдэг бодит нотолгоо байвал тухайн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үздэг. Арилжаалах боломжтой хэрэгсэлд хийсэн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь өртгөөсөө их хэмжээгээр буурах эсвэл бууралт нь удаан хугацаагаар үргэлжлэхийг үнэ цэнэ бууралтын бодит нотолгоо гэж үздэг.

Бусад бүх санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоонд:

- үнэт цаас гаргагч буюу харилцагч тал ихээхэн санхүүгийн хүндрэлтэй болох;
- гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, тухайлбал хүү ба үндсэн төлбөрийн хугацааг хэтрүүлэх, төлж чадахгүй болох;
- зээлдэгч нь дампуурлаа зарлах эсвэл санхүүгийн хувьд дахин бүтцийн өөрчлөлт хийх магадлалтай болсон; эсвэл
- санхүүгийн хүндрэлийн улмаас тухайн санхүүгийн хөрөнгийн идэвхтэй зах зээл үгүй болсон гэх зэрэг орно.

Дансны авлага гэх мэт зарим санхүүгийн хөрөнгө нь дангаараа үнэ цэнийн бууралтад өртөөгүй гэж үзсэн ч нийт багцын хувьд үнэ цэнийн бууралт явагдсан эсэхийг шалгана.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Компанийн авлагаа цуглуулдаг туршлага, 30 хоногийн дундаж зээлийн хоногоос хугацаа хэтэрсэн авлагын тоо нийт авлагын багцад өссөн, мөн авлага төлөгдөхгүй, төлбөрийн чадваргүй болж байгаа нь улсын болон орон нутгийн эдийн засгийн нөхцөл байдал мэдэгдэхүйц өөрчлөлттэй холбоотой байвал авлагын багцын үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо гэж үздэг.

Хорогдуулсан өргтөөр хэмжигддэг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг тухайн хөрөнгийн анх олж бэлтгэх үеийн хүүгийн хувиар дискаунтласан ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлно. Өргтөөр хэмжигддэг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг ижил тестэй хөрөнгийн одоогийн зах зээлийн хүүгийн хувиар дискаунтласан ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлно. Ийм үнэ цэнийн бууралтын алдагдлыг хожим нь буцааж бүртгэдэггүй.

Авлагаас бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг тухайн хөрөнгийн дансны үнийг бууруулж бүртгэнэ. Худалдааны авлагын хувьд эргэлзээтэй авлагын сангийн дансаар дамжуулж үнэ цэнэ бууралтын алдагдлыг бүртгэдэг. Авлагыг цуглуулах найдваргүй гэж үзвэл авлагыг эргэлзээтэй авлагын сан руу хааж данснаас хасдаг. Данснаас хассан авлага нь хожим нь төлөгдвэл эргэлзээтэй авлагын санд бичилтийг буцаана. Эргэлзээтэй авлагын сангийн дансны үлдэгдлийн өөрчлөлтийг ашиг алдагдалд тусгана.

Хорогдуулсан өргтөөр хэмжигддэг санхүүгийн хөрөнгийн хувьд дараачийн санхүүгийн жилд үнэ цэнийн бууралтын алдагдал буурсан ба ийнхүү буурсан нь үнэ цэнийн алдагдлыг бүртгэсний дараа бий болсон үйл явдалтай холбоотой гэдэг нь бодитойгоор нотлогдож байвал өмнө бүртгэсэн үнэ цэнэ бууралтын алдагдлыг буцаана. Ингэхдээ үнэ цэнийн бууралт бүртгээгүй байсан бол байх байсан Хөрөнгийн хорогдуулсан өргтгийг бууруулахгүй байхаар бодож үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана.

5.12 Санхүүгийн өр төлбөр ба өмчийн хэрэгсэл

Өр эсвэл өмчийн хэрэгслээр ангилах

Компаниас гаргаж байгаа өрийн болон өмчийн хэрэгслийг тэдгээрийн гэрээнд тусгагдсанаар ямар нөхцөл, бодит байдал үүссэн бөгөөд санхүүгийн ор эсвэл өмчийн хэрэгслийн тодорхойлолтод нийцэж байгаа эсэхийг үндэслэн өр эсвэл өмчийн хэрэгсэл гэж ангилдаг.

Өмчийн хэрэгсэл

Компанийн бүх хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгээс хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэдэг. Компаниас гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжиж бүртгэдэг.

Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг "бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг" өрийн хэрэгсэл эсвэл бусад санхүүгийн өр төлбөр гэж хоёр ангилдаг. Компанийн санхүүгийн өр толбор нь бусад санхүүгийн өр төлбөрөөс бүрдэнэ.

Санхүүгийн бусад өр төлбөр

Бусад санхүүгийн өрийг (үүнд зээлийн өр болон дансны ба бусад өглөг багтана) бодит хүүгийн аргаар хорогдуулсан өргтөөр хэмжих бүртгэнэ. Бодит хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өрийн хорогдуулсан өргтгийг бodoх ба хүү тооцох хугацааны турш бүртгэх хүүгийн зардлыг хуваарилах арга юм.

Бодит хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр (бодит хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан)- ийг санхүүгийн өрийн гэрээний хугацааны эцэс гэхэд анх бүртгэсэн дансны цэвэр дүнтэй яг тэнцүү байхаар төлбөрийг өрийн хугацаа эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хуваарилахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Санхүүгийн ерийг бүртгэлээс хасах

Компани нь санхүүгийн өр төлберийг зөвхөн гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд бүртгэлээс хасна. Бүртгэлээс хасаж буй санхүүгийн ерийн дансны үнэ ба түүний оронд хүлээн авсан ба авах хэрэгслийн хооронд үнийн зөрүү байвал ашиг алдагдаар бүртгэнэ.

Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ

Компанийн удирдлага санхүүгийн хэрэгслүүдийн богино хугацаат чанаас үзээд тухайн санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг зөрүүгүй гэж үзсэн.

5.13 Хугацаатай хадгаламж

Хугацаатай хадгаламж нь дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан гурван чанаас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификат хамруулна.

5.14 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан дахь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь банканд байршуулсан болон гар дээрх бэлэн мөнгө, гурван сар болон хугацаагүй хадгаламж орно. Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах Хөрөнгийг мөнгө болон богино хугацаатай хадгаламжаас банкны овердрафтыг хассан дүнгээр тодорхойлно.

5.15 Урьдчилж төлсөн зардал ба бусад авлага

Урьдчилж төлсөн зардал ба бусад авлага нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь гарч амжаагүй төлбөр эсвэл бараа материалыа хүлээн аваагүй төлбөрөөс бүрдэнэ. Урьдчилгаа төлберийг анх хөрөнгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлберийг тухайн зардал нь гарсан тохиолдолд ашиг, алдагдал руу, бараагаа хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгө рүү ангилдаг. Урьдчилгаа төлбөртэй холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагадах бол урьдчилгаа төлберийг санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд эргэлтийн бус хөрөнгөөр ангилна. Тайлант жилийн эцэст Компани урьдчилгаа төлберийн дансны үнэд үнэ цэнийн бууралт гарсан эсэхийг хянадаг.

5.16 Эздийн өмч

Өөрийн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой гүйлгээний зардлыг татварын дараах дүнгээр нь өөрийн хөрөнгөөс хасна. Өөрийн хөрөнгийн гүйлгээний өртөгт зөвхөн өөрийн хөрөнгийн гүйлгээнд шууд холбоотой гаднын зардлууд орно.

Эзэмшигчдийн өмч ба нэмж төлөгдсөн капитал

Энгийн капитал нь эздийн өмч гэж ангилагдана. Энгийн хувьцааны ногдол ашиг нь зарлагдсан үедээ зэдийн өмчөөр бүртгэгдэнэ. Дансны үнэ болон дахин гаргах үеийн зөрүү нь нэмж төлөгдсөн капитал болно.

Тусгай нөөц сан

Тусгай нөөц сан нь Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор ирээдүйн болзошгүй гамшигт үзээгдлүүдэд зориулж 2016 онд байгуулагдсан. Тусгай нөөц сангийн дун нь 2015 оны 12 сарын 31-ний Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн 90 хувьтай тэнцүү байна. Тусгай нөөц сангийн дун анх байгуулагдсанаас хойш өөрчлөгдөөгүй.

Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг нь хуримтлуулсан ашиг алдагдлын дүнгээс зарласан ногдол ашигийг хассан дүнгээр тодорхойлогоно.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

6. Даатгалын орлого, зардал ба үр дүн

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Хураамжийн хуваарилалтын арга ("ХХА")-аар бүртгэгдэх даатгалын гэрээний орлого	17,554,215	10,516,230
Даатгалын үйлчилгээний зардал		
Нөхөн төлбөр болон бусад холбогдох зардал	(7,515,847)	(4,865,459)
Өнгөрсөн хугацааны даатгалын үйлчилгээний өөрчлөлт – Учирсан хохирлын залруулга	528,252	320,421
Учирсан хохирлын өр төлбөрийн залруулга	(1,565,494)	1,535,225
Даатгалын мөнгөн зарлага (хорогдуулах)	(2,691,882)	(1,524,949)
Даатгалын үйлчилгээний нийт зардал – Тодруулга 9	(11,244,971)	(4,534,762)
Даатгалын гэрээний орлого / (зардал)		
Давхар даатгалын зардал – ХХА -аар бүртгэгдэх	385,936	(39,353)
Давхар даатгачаас төлсөн нөхөн төлбөр	1,347,787	579,943
Өнгөрсөн хугацааны даатгалын үйлчилгээний өөрчлөлт – Учирсан хохирлын залруулга	134,201	(408,592)
Даатгалын гэрээний цэвэр орлого	1,867,923	131,998
Даатгалын үйлчилгээний цэвэр үр дүн – ашиг	8,177,167	6,113,466

ХХА – Хураамжийн хуваарилалтын арга
УХӨТ – Учирсан хохирлын өр төлбөр

7. Хөрөнгө оруулалтын орлого

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөренгийн хүүний орлого	4,937,142	3,248,822
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх хөренгө оруулалтын олз	1,817,093	349,090
Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөренгийг үл хүлээн зөвшөөрөхөөс үүссэн олз	-	133,168
Санхүүгийн болон гэрээний хөренгийн үнэ цэнийн бууралтаас үүссэн гарз (үнэ цэнийн бууралтын буцаалтаас үүссэн олз) (Тодруулга 14)	(376,481)	(5,193)
Нийт хөрөнгө оруулалтын орлого	6,377,754	3,725,887

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх хөрөнгө оруулалтын дахин үнэлгээнээс Компани 2024 онд 141,900 мянган төгрөгийн гарз хүлээн зөвшөөрсөн.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

7.1 Санхүүгийн хөрөнгө, гэрээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтын өөрчлөлтөөс үүссэн олз, гарз

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Хүлээгдэж буй хөрөнгө оруулалтын алдагдлын сангийн зардал - Тодруулга 14.1	365,609	-
Бусад гарз	10,872	5,193
Нийт дүн	376,481	5,193

8. Үйл ажиллагааны бусад зардал

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Цалин, урамшууллын зардал	3,993,200	2,635,471
Мэргэжлийн үйлчилгээний зардал	553,051	338,659
Маркетингийн зардал	301,657	252,102
Шуудан, холбооны зардал	214,963	250,045
Идэвхжүүлэлтийн зардал	482,846	207,367
Элэгдэл – Тод 8.1	225,271	182,874
Захиргаа, үйлчилгээний шимтгэл	96,104	79,119
Албан томилолтын зардал	62,859	56,062
Гишүүнчлэл, аудитын зардал	102,137	54,271
Түрээсийн зардал	57,728	38,273
Тээврийн зардал	21,693	35,019
Ашиглалтын зардал	39,129	34,980
Засвар үйлчилгээний зардал	16,151	28,601
Даатгалын зардал	41,164	23,305
Сургалтын зардал	86,240	17,604
Хорогдлын зардал – Тодруулга 21	7,969	7,969
Бусад	354,898	171,011
Нийт дүн	6,657,060	4,412,732

8.1 Элэгдлийн зардал

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Үндсэн хөрөнгийн элэгдэл – Тод 19	138,170	107,339
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл – Тод 20.1 & 20.3	87,101	57,020
Нийт элэгдлийн зардал – Тод 8	225,271	182,874

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9. Даатгалын үйлчилгээний орлого, үр дүн

9.1 2024 оны даатгалын үйлчилгээний орлого, үр дүн

2024 (Мянган төгрөгөөр)	Даатгалын гэрээний хөрөнгө	Үлдсэн хугацаанд хамаарах өр төлбөр	Учирсан хохирлын өр төлбөр	Нийт
2024 оны 1 сарын 1-ээрх даатгалын гэрээний өр төлбөр	-	7,264,594	2,755,073	10,019,667
2024 оны 1 сарын 1-ээрх даатгалын гэрээний хөрөнгө	(1,089,143)	-	-	(1,089,143)
2024 оны 1 сарын 1-ээрх цэвэр дүн	(1,089,143)	7,264,594	2,755,073	8,930,524
Даатгалын гэрээний орлого – Тод 6	-	(17,554,215)	-	(17,554,215)
Даатгалын үйлчилгээний зардал – Тод 6				
Нөхөн төлбөр ба бусад холбогдох зардал	-	-	7,515,847	7,515,847
Өнгөрсөн хугацааны даатгалын үйлчилгээний өөрчлөлт – Учирсан хохирлын залруулга	-	-	(528,252)	(528,252)
Учирсан хохирлын өр төлбөрийн залруулга	-	-	1,565,494	1,565,494
Даатгалын зардлын хорогдуулалт	2,691,882	-	-	2,691,882
Нийт даатгалын үйлчилгээний зардал Тод 6	2,691,882	-	8,553,089	11,244,971
Мөнгөн гүйлгээ				
Хүлээн авсан хураамж	-	16,086,754	-	16,086,754
Нөхөн төлбөр ба бусад даатгалын үйлчилгээний зардлын төлөлт	-	-	(7,650,048)	(7,650,048)
Үлдсэн хугацаанд хамаарах өр төлбөрийн өөрчлөлт	-	4,269,387	-	4,269,387
Даатгалын мөнгөн зарлага (хорогдуулах)	(3,166,603)	-	-	(3,166,603)
Цэвэр мөнгөн гүйлгээ	(3,166,603)	20,356,141	(7,650,048)	9,539,490
2024 оны 12 сарын 31-ээрх цэвэр дүн	(1,563,864)	10,066,520	3,658,114	12,160,770
2024 оны 12 сарын 31-ээрх даатгалын гэрээний өр төлбөр	-	10,066,520	3,658,114	13,724,634
2024 оны 12 сарын 31-ээрх даатгалын гэрээний хөрөнгө	(1,563,864)	-	-	(1,563,864)
2024 оны 12 сарын 31-ээрх цэвэр дүн	(1,563,864)	10,066,520	3,658,114	12,160,770

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9.2 2023 оны даатгалын үйлчилгээний орлого, үр дүн

2023 (Мянган төгрөгөөд)	Даатгалын гэрээний хөрөнгө	Үлдсэн хугацаанд хамаарах өр төлбөр	Учирсан хохирлын өр төлбөр	Нийт
2023 оны 1 сарын 1-ээрх даатгалын гэрээний өр төлбөр	-	4,227,898	4,202,129	8,430,027
2023 оны 1 сарын 1-ээрх даатгалын гэрээний хөрөнгө	(608,273)	-	-	(608,273)
2023 оны 1 сарын 1-ээрх цэвэр дүн	(608,273)	4,227,898	4,202,129	7,821,754
Даатгалын гэрээний орлого – Тод 6	-	(10,516,230)	-	(10,516,230)
Даатгалын үйлчилгээний зардал – Тод 6				
Нехөн төлбөр ба бусад холбогдох зардал	-	-	4,865,459	4,865,459
Өнгөрсөн хугацааны даатгалын үйлчилгээний өөрчлөлт – Учирсан хохирлын залруулга	-	-	(320,421)	(320,421)
Учирсан хохирлын өр төлбөрийн залруулга	-	-	(1,535,225)	(1,535,225)
Даатгалын зардлын хорогдуулалт	1,524,949	-	-	1,524,949
Нийт даатгалын үйлчилгээний зардал Тод 6	1,524,949	-	3,009,813	4,534,762
Мөнгөн гүйлгээ				
Хүлээн авсан хураамж	-	16,086,754	-	16,086,754
Нехөн төлбөр ба бусад даатгалын үйлчилгээний зардлын төлөлт	-	-	(4,456,869)	(4,456,869)
Үлдсэн хугацаанд хамаарах өр төлбөрийн өөрчлөлт	-	(2,533,828)	-	(2,533,828)
Даатгалын мөнгөн зарлага (хорогдуулах)	(2,005,819)	-	-	(2,005,819)
Цэвэр мөнгөн гүйлгээ	(2,005,819)	13,552,926	(4,456,869)	7,090,238
2023 оны 12 сарын 31-ээрх цэвэр дүн	(1,089,143)	7,264,594	2,755,073	8,930,524
2023 оны 12 сарын 31-ээрх даатгалын гэрээний өр төлбөр	-	7,264,594	2,755,073	10,019,667
2023 оны 12 сарын 31-ээрх даатгалын гэрээний хөрөнгө	(1,089,143)	-	-	(1,089,143)
2023 оны 12 сарын 31-ээрх цэвэр дүн	(1,089,143)	7,264,594	2,755,073	8,930,524

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

10. Бусад олз / (гарз)

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Гадаад валютын ханшийн хэрэгжсэн олз	235,659	130,254
Үндсэн хөрөнгө борлуулснаас олсон олз	1,235	104,776
Гадаад валютын ханшийн хэрэгжээгүй олз / (гарз)	(2,569)	18,220
Бусад	(30,645)	79,871
Нийт дүн	203,680	333,121

11. Орлогын албан татвар

11.1 Тайлант жилийн орлогын албан татварын зардал

2024 оны 12 сарын 31-ний байдлаар орлогын албан татварын зардлын бүтэц дараах байдалтай байсан:

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Тайлант жилийн үр дүнд ногдох орлогын албан татварын зардал	769,587	520,524
Түр зөрүү болон түр зөрүүний буцаалттай холбоотой хойшлогдсон татварын хөдөлгөөн	154,058	65,146
Тайлант жилийн нийт орлогын албан татварын зардал	923,645	585,670

Компани тайлант жилийн орлогын дүнг орлогын татварын хуульд заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр запруулсан дүнг үндэслэн орлогын албан татварын зардлыг тооцдог. Компани 6 тэрбум (2022: 6 тэрбум) төгрөг хүртэлх ашгаас 10%, 6 тэрбум төгрөгөөс дээш ашгаас 25%-ийн орлогын албан татвар төлдөг. Хүүгийн орлогод 10% татвар төлдөг.

11.2 Орлогын албан татварын зардлын задаргаа

Тайлант жилийн орлогын албан татварын зардлын задаргаа дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Татварын өмнөх ашиг	8,089,401	5,743,143
Татварын өмнөх ашгаас нийтлэг хувь хэмжээгээр (2024: 10%, 2023: 10%)-иар тооцсон орлогын албан татвар	808,940	574,314
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нөлөө	(39,353)	(18,119)
Хойшлогдсон татвар өр телбөр/ (хөрөнгө)-ийн хүлээн зөвшөөрөлт	154,058	29,475
Тайлант жилийн нийт орлогын албан татварын зардал	923,645	585,670

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

11.3 Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн тайлант жилийн хөдөлгөөнийг дараах хүснэгтэд харуулав:

(Мянган төгрөгөөр)	2024	2023
1 сарын 1-ээрх хойшлогдсон татварын хөрөнгө / (өр төлбөр)	(29,475)	35,671
Татварын түр зөрүүгээс үүссэн хөдөлгөөн	(154,058)	(65,146)
12 сарын 31-ээрх хойшлогдсон татварын хөрөнгө / (өр	(183,533)	(29,475)

2024 онд төгрөгийн татварын түр зөрүүний хөдөлгөөнөөс 154,058 мянган төгрөг (2023: 65,146 мянган төгрөг)-ийн хойшлогдсон татварын өр төлбөр хүлээн зөвшөөрсөн.

	Санхүү байдлын тайлан		Ашиг, алдагдлын тайлан	
	2024.12.31	2023.12.31	2024	2023
Хуримтлуулж олгосон цалин болон бусад зардал	45,000	16,594	28,406	(24,879)
Санхүүгийн хөрөнгийн хэрэгжээгүй олз	(210,200)	(28,491)	(181,709)	(28,491)
Гадаад валютын хэрэгжээгүй олз	259	(1,822)	2,081	(1,822)
Ашиглах эрхтэй хөрөнгө	(3,757)	456	(4,214)	(93)
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зөрүү	(14,834)	(16,212)	1,378	(9,965)
Хойшлогдсон шимтгэлийн зардал / (орлого)	-	-	-	104
Ашиг, алдагдлын тайлан дахь нөлөө	-	-	(154,058)	(65,146)
12 сарын 31-ээрх хойшлогдсон татварын хөрөнгө / (өр төлбөр)	(183,532)	(29,475)	-	-

11.4 Орлогын албан татварын өр төлбөр

Тайлант жилийн орлогын албан татварын өр төлбөрийн хөдөлгөөнийг дараах байдлаар харуулав:

(Мянган төгрөгөөр)	2024	2023
1 сарын 1-ээрх орлогын албан татварын өр төлбөр	144,337	11,733
Тайлант жилийн орлогын албан татварын зардал	923,645	520,524
Төлөгдсөн татвар	(940,192)	(387,920)
12 сарын 31-ээрх орлогын албан татварын өр төлбөр	127,790	144,337

Монгол Улсын татвар, валют болон гаалийн тухай хуулиудын талаарх ойлголтууд нь ялгаатай байх тохиолдлууд байдаг ба тэдгээр хуулиуд нилээд өөрчлөгдөж байдаг. Эдгээр хуулиудыг удирдлага нь Компанийн ажил гүйлгээ, үйл ажиллагаанд өөрсдийн ойлголт, тайлбарын хүрээнд хэрэгжүүлж байгаа боловч аливаа татварын эрх бүхий байгууллагуудын сорилттой тулгарч болно. Монгол Улсын татварын эрх бүхий байгууллага нь өөрийн хуулийн талаарх тайлбар болон байр сууриндаа илүү хатуу хандаж болох бөгөөд өмнө нь татварын аливаа асуудал үүсч байгаагүй ажил гүйлгээ, үйл ажиллагаанд татварын аливаа асуудал үүсэхийг үгүйсгэхгүй юм.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Үүний үр дүнд, нөлөөлөхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон хүүг ногдуулж болох юм. Татварын шалгалт хийх хугацааны хувьд шалгалт хийх тайлант жилээс өмнөх 4 (2020 он хүртэл: 5 жил байсан) жилийн хугацааг хамарч болно. Зарим тухайлсан тохиолдолд түүнээс ч урт хугацааг хамарч болно. Үнэ шилжилттэй холбоотой Монгол Улсын хуулийн заалтууд нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ба тодорхой онцлог шинж чанарыг агуулсан ч Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас боловсруулсан олон улсын үнэ шилжилттэй холбоотой зарчимд ерөнхийдөө суурисан. Үнэ шилжилттэй холбоотой хуулийн зохицуулалт нь тухайн байгууллагын хяналтанд байгаа ажил гүйлгээнүүд (холбоотой талуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээ, мөн зарим холбоогүй талуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээ) хэрэв сунгасан гарын зарчмаар хэрэгжээгүй бол татварын аливаа эрсдэл үүсэх зохицуулалттай. Удирдлага нь одоогийн үнэ шилжилттэй холбоотой хууль тогтоомжийг дагаж мөрдөх төлөвлөгөө, журмыг хэрэгжүүлж байгаа.

Монгол Улсын татварын хууль тогтоомжийн зарим хэсэгт илт тодорхой удирдамж байдаггүйгээс тухайн хуулийн тодорхойгүй хэсгийг Компанийн зүгээс ойлгон хэрэгжүүлсэн нь татварын хувь хэмжээг бууруулсан үр дүнд хүргэсэн байж болно. Компанийн удирдлага нь өөрийн хэрэгжүүлж буй татварын байр суурь, тайлбарыг үндэслэлтэй гэж тооцоолж байгаа боловч татварын эрх бүхий байгууллагын зүгээс уг байр суурь, тайлбартай холбоотой асуудал үүсгэвэл татварын боломжит эрсдэл үүсч болзошгүй юм. Үүсч болох уг татварын эрсдлийн үр нөлөөг найдвартай тооцоолох боломжгүй боловч энэ нь Компанийн санхүүгийн байдал эсвэл ерөнхий үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөтэй байх магадлалтай юм.

12. Бусад дэлгэрэнгүй орлого / (алдагдал)

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Үнэт цаасны дахин үнэлгээний олз / (гарз)	(141,900)	42,417
Хөрөнгийн дахин үнэлгээний олз	-	1,122,806
Нийт бусад дэлгэрэнгүй олз / (гарз)	(141,900)	1,165,223

13. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

(Мянган төгрөг)	2024.12.31	2023.12.31
Банкин дахь мөнгө	92,104	132,393
Хугацаагүй хадгаламж	5,814	79,724
Нийт дүн	97,918	212,117

13.1 Харилцах дах бэлэн мөнгө - валютаар

(Мянган төгрөг)	2024.12.31	2023.12.31
Харилцах дах бэлэн мөнгө - төгрөг	82,133	122,341
Харилцах дах бэлэн мөнгө - ам.доллар	9,971	10,052
Нийт дүн	92,104	132,393

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

13.2 Хугацаагүй хадгаламж - валютаар

(Мянган төгрөг)	2024.12.31	2023.12.31
Хугацаагүй хадгаламж - төгрөг	3,810	15,192
Хугацаагүй хадгаламж - ам.доллар	2,004	64,532
Нийт дүн	5,814	79,724

13.3 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө - валютаар

(Валютаар)	2024.12.31	2023.12.31
Төгрөг	85,942,866	137,533,558
Ам.доллар	3,561	21,868

13.4 Харилцах дахь бэлэн мөнгө – зээлжих зэрэглэл

(Мянган төгрөг)	2024.12.31	2023.12.31
Маш сайн	-	-
Хангалттай	97,918	212,117
Тусгай хяналттай	-	-
Нийт дүн	97,918	212,117

14. Санхүүгийн хөрөнгө

	Хорогдуулсан өртгөөр бүртгэх	Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланда бүртгэгдэх	Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланда	Нийт
2024 оны 12 сарын 31-ээрх				
Санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламжууд	30,867,491	-	-	30,867,491
Засгийн газрын гаргасан бонд	-	-	-	-
Бусад өрийн хэрэгслүүд	6,660,992	-	-	6,660,992
Өмчийн хэрэгслүүд	-	-	2,021,637	2,021,637
Хөрөнгө оруулалтын санд байршуулсан	-	8,272,713	-	8,272,713
Нийт дүн	37,528,483	8,272,713	2,021,637	47,822,833
 Хүлээгдэж буй хөрөнгө оруулалтын алдагдлын сан	 (365,609)	 -	 -	 (365,609)
Цэвэр дүн	37,162,874	8,272,713	2,021,637	47,457,224

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2023 оны 12 сарын 31-ээрх	Хорогдуулсан өртгөөр бүртгэх	Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланда бүртгэгдэх	Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланда	Нийт
Санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламжууд	15,406,613	-	-	15,406,613
Засгийн газрын гаргасан бонд	-	-	-	-
Бусад өрийн хэрэгслүүд	11,608,885	-	-	11,608,885
Өмчийн хэрэгслүүд	-	-	1,299,134	1,299,134
Хөрөнгө оруулалтын санд байршуулсан	-	1,764,342	-	1,764,342
Нийт дүн	27,015,498	1,764,342	1,299,134	30,078,974

Компани санхүүгийн хөрөнгөөс 2024 онд нийт 6,377,754 мянган төгрөг (2022: 3,725,887 мянган төгрөг)-ийн орлого олсон болно (Тодруулга 7).

14.1 Санхүүгийн хөрөнгө – Хүлээгдэж буй хөрөнгө оруулалтын алдагдал

Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх хорогдуулах өртгөөр бүртгэх санхүүгийн (хөрөнгө оруулалт) хөрөнгийн зээлжих зэрэглэл болон байгуулсан хөрөнгө оруулалтын алдагдлын санг дараах хүснэгтээс харна уу.

2024 оны 12 сарын 31	Шатлал 1 (12 сарын ХБХОА)	Шатлал 2	Шатлал 3	Нийт
AAA - AA зэрэглэл	-	-	-	-
A - BBB зэрэглэл	-	-	-	-
BB - B зэрэглэл	37,528,483	-	-	37,528,483
Нийт дүн	37,528,483	-	-	37,528,483
Хүлээгдэж буй хөрөнгө оруулалтын алдагдлын сан	(365,609)	-	-	(365,609)
Нийт цэвэр дүн	37,162,874	-	-	37,162,874

ХБХОА – Хүлээгдэж буй хөрөнгө оруулалтын алдагдал

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

15. Даатгалын гэрээний хөрөнгө ба өр төлбөр

2024 оны 12 сарын 31 (Мянган төгрөгөөр)	Богино хугацаат	Урт хугацаат	Нийт
Даатгалын гэрээний хөрөнгө	(2,131,854)	-	(2,131,854)
Даатгалын гэрээний өр төлбөр	13,724,634	-	13,724,634
Давхар даатгалын гэрээний хөрөнгө	(106,456)	-	(106,456)
Давхар даатгалын гэрээний өр төлбөр	425,827	-	425,827
	11,912,151	-	11,912,151

2023 оны 12 сарын 31 (Мянган төгрөгөөр)	Богино хугацаат	Урт хугацаат	Нийт
Даатгалын гэрээний хөрөнгө	(1,119,387)	-	(1,119,387)
Даатгалын гэрээний өр төлбөр	10,019,667	-	10,019,667
Давхар даатгалын гэрээний хөрөнгө	(498,835)	-	(498,835)
Давхар даатгалын гэрээний өр төлбөр	463,809	-	463,809
	8,865,254	-	8,865,254

Давхар даатгалын гэрээний хөрөнгө ба өр төлбөр

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Давхар даатгалын гэрээний хөрөнгө	106,456	498,835
Давхар даатгалын гэрээний өр төлбөр	(425,827)	(463,809)
Давхар даатгалын гэрээний цэвэр хөрөнгийн дүн	(319,371)	35,026

16. Авлага

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Байгууллагаас авах	114,541	66,637
Ажиллагсдаас авах	14,436	8,437
Нийт дүн	128,977	75,074
Хасах нь: Найдваргүй авлагын хасагдуулга	(21,379)	(31,879)
Цэвэр дүн	107,598	43,195

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

16.1. Найдваргүй авлагын хасагдуулга

Найдваргүй авлагын хасагдуулгын дүн:

(Мянган төгрөгөөр)	2024	2023
1 сарын 1-ээрх үлдэгдэл	31,879	26,749
Тайлант жилд байгуулсан хасагдуулга	-	5,193
Тайлант жилд данснаас хассан	(10,500)	(63)
12 сарын 31-ээрх үлдэгдэл	21,379	31,879

17. Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо ба бусад хөрөнгө

(мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Урьдчилж төлсөн зардал	296,536	253,866
Бусад татварын авлага	19,678	3,526
Нийт дүн	316,214	257,392

18. Бараа материал

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Бичиг хэргийн хангамжийн материал	23,514	24,715
Бусад оффисийн хангамжийн материал	33,858	19,069
Нийт дүн	57,372	43,784

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн өөрчлөлт, хөдөлгөөн дараах байдалтай байна. Компани нь үндсэн хөрөнгөө өргтийн загвар ашиглан бүртгэсэн, хөрөнгийн дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах зорилгоор хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрд хянаж үздэг.

2024 оны 12 сарын 31 (Мянган төгрөгөөр)	Барилга	Компьютер, дагалдах хэрэгсэл	Тавилга, эд хогшил	Тээврийн хэрэгсэл	Нийт
Өртөг / Дахин үнэлгээ					
2024 оны 1 сарын 1	1,960,629	562,328	206,641	200,719	2,930,317
Нэмэгдэл	-	97,711	38,055	350,000	485,766
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-
Хасагдсан	-	(1,293)	(10,314)	-	(11,607)
Данснаас хасагдсан	-	(25,768)	(19,631)	-	(45,399)
2024 оны 12 сарын 31	1,960,629	632,978	214,751	550,719	3,359,077
Хуримтлагдсан элэгдэл					
2024 оны 1 сарын 1	221,069	460,283	97,098	86,413	864,863
Нэмэгдсэн (Тод 8.1)	20,946	65,848	18,297	33,079	138,170
Хасагдсан	-	(1,293)	(8,800)	-	(10,093)
Данснаас хасагдсан	-	(25,768)	(11,761)	-	(37,529)
2024 оны 12 сарын 31	242,015	499,070	(94,834)	119,492	955,411
Цэвэр дансны үнэ					
2024 оны 12 сарын 31	1,718,614	133,908	119,917	431,227	2,403,666

2023 оны 12 сарын 31 (Мянган төгрөгөөр)	Барилга	Компьютер, дагалдах хэрэгсэл	Тавилга, эд хогшил	Тээврийн хэрэгсэл	Нийт
Өртөг / Дахин үнэлгээ					
2023 оны 1 сарын 1	837,823	474,726	234,070	391,144	1,937,763
Нэмэгдэл	-	120,853	22,682	93,500	237,035
Дахин үнэлгээний нэмэгдэл – Тод 12	1,122,806	-	-	-	1,122,806
Хасагдсан	-	(15,113)	(18,730)	(283,925)	(317,768)
Данснаас хасагдсан	-	(18,138)	(31,381)	-	(49,519)
2023 оны 12 сарын 31	1,960,629	562,328	206,641	200,719	2,930,317
Хуримтлагдсан элэгдэл					
2023 оны 1 сарын 1	200,123	457,634	110,102	202,531	970,390
Нэмэгдсэн (Тод 8.1)	20,946	35,114	20,782	30,497	107,339
Хасагдсан	-	(14,327)	(13,387)	(146,615)	(174,329)
Данснаас хасагдсан	-	(18,138)	(20,399)	-	(38,537)
2023 оны 12 сарын 31	221,069	460,283	97,098	86,413	864,863
Цэвэр дансны үнэ					
2023 оны 12 сарын 31	1,739,560	102,045	109,543	114,306	2,065,454

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

20. Түрээс

20.1. Ашиглах эрхтэй хөрөнгө

Байгуулгын ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үнэ болон тайлант хугацаан дахь дансны хөдөлгөөнийг дараах хүснэгтэд харуулав:

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Өртөг		
1 сарын 1-ээрх	357,255	195,538
Нэмэгдсэн	114,361	174,194
Данснаас хассан	(2,518)	(38,957)
Түрээсийн хугацааны өөрчлөлт	(12,043)	26,480
12 сарын 31-ээрх	457,055	357,255
 Хуримтлагдсан элэгдэл		
1 сарын 1-ээрх	204,064	167,487
Тайлант жилд нэмж байгуулсан – Тодруулга 8.1 & 19.3	87,101	75,535
Данснаас хассан	(2,518)	(38,958)
Түрээсийн хугацааны өөрчлөлт	-	-
12 сарын 31-ээрх	288,647	204,064
 12 сарын 31-ээрх дансны цэвэр дүн	168,408	153,191

20.2. Түрээсийн өр төлбөр

Компанийн түрээсийн өглөгийн дансны үнэ, тухайн жилийн хөдөлгөөнийг дараах хүснэгтэд харуулав:

(Мянган төгрөгөөр)	2024	2023
1 сарын 1-ээрх	143,105	29,886
Нэмэгдсэн	107,939	174,194
Дуусгавар болсон	(2,518)	(37,845)
Түрээсийн хугацааны өөрчлөлт	-	47,847
Хуримтлагдсан хүү	12,208	16,601
Төлбөр төлөлт	(123,918)	(87,578)
12 сарын 31-ээрх	136,816	143,105

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

20.3. Ашиг, алдагдлын тайлан дахь нөлөөлөл

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Элэгдлийн зардал – Тодруулга 8.1 & 19.1	87,101	75,535
Түрээсийн өр төлбөрийн хүүний зардал	12,208	16,601
Нийт дүн	99,309	92,136

20.4. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зарцуулалт – Ашиглах эрхтэй хөрөнгө

(Мянган төгрөгөөр)	2024	2023
<i>Мөнгөн бус гүйлгээ</i>		
Ашиглах эрхтэй хөрөнгийн нэмэгдэл	(82,034)	(107,527)
<i>Мөнгөн гүйлгээ</i>		
Түрээсийн сайжруулалтын нэмэгдэл	(32,327)	(66,667)
Нийт дүн	(114,361)	(174,194)

21. Биет бус хөрөнгө

(Мянган төгрөгөөр)	2024	2023
<i>Өртөг</i>		
1 сарын 1-ээрх	317,459	317,459
Нэмэгдсэн	-	-
Данснаас хассан	-	-
12 сарын 31-ээрх	317,459	317,459
<i>Хуриимтлагдсан хороодол</i>		
1 сарын 1-ээрх	261,677	253,708
Тайлант жилд нэмж байгуулсан – Тодруулга 10	7,969	7,969
Данснаас хассан	-	-
12 сарын 31-ээрх	269,646	261,677
<i>Дансны цэвэр дүн</i>		
12 сарын 31-ээрх	47,813	55,782

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

22. Дансны ба бусад өр төлбөр

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Хүлээн авсан урьдчилгаа	125,463	49,576
Бусад өр төлбөр*	810,178	571,458
Хувь хүний орлогын албан татварын өр төлбөр	92,203	207,407
Нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр	50	182
Бусад татварын өр төлбөр	-	5,173
Нийт дүн	1,027,894	833,795

Бусад өглөт цалингийн өглөг, хувь хүнд өгөх өглөг, нөхөн төлбөрийн өглөг болон бусад өглөг багтав. Дансны ба бусад өр төлбөрүүд хүүгүй ба барьцаа хөрөнгөөр баталгаажаагүй болно.

23. Хувьцаат капитал

2024 оны 12 сарын 31-ний тайлант хугацаагаарх хувь нийлүүлсэн хөрөнгө 6,000,000 мянган төгрөгийн дүнтэй байсан ба нэгж хувьцаа нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 60 сая ширхэг энгийн хувьцаа (2023: нэг бүр нь 1 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй 5,000 ширхэг энгийн хувьцаа)-аас бүрдсэн. Компани нь Улсын бүртгэлийн ерөнхий газарт Улсын бүртгэлийн (регистрийн дугаар) № 2648016 дугаараар бүртгэлтэй.

	Энгийн хувьцааны тоо		Энгийн хувьцааны дансны дүн (мянган төгрөгөөр)	
	2024	2023	2024	2023
12 сарын 31-ээрх	60,000,000	5,000	6,000,000	5,000,000

23.1 Нэмж төлөгдсөн капитал

(Мянган төгрөгөө)	2024	2023
1 сарын 1-ээр үлдэгдэл	130,000	130,000
Нэмж төлөгдсөн капиталын нэмэгдэл*	6,350,250	-
12 сарын 31-ээр үлдэгдэл	6,480,250	130,000

* Санхүүгийн Зохицуулах Хорооны 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 413 тоот тогтоолоор Компанийг нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 60 сая энгийн хувьцаатай байхыг хүлээн зөвшөөрсөн. Мөн уг тогтоолоор Компанийг өөрийн 12,500,000 ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар ширхэг тус бүрийг 800 төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг зөвшөөрсөн (Тодруулга 1-ийг харна уу).

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

24. Ердийн даатгалын нөөц сангүүд

Ердийн даатгалын нөөц сангүүдиг дараах байдлаар харуулав:

	2024 оны 12 дугаар сарын 31 (мянган төгрөгөөр)			2023 оны 12 дугаар сарын 31 (мянган төгрөгөөр)		
	Даатгалын нөөц сан	Давхар даатгагчид ногдох	Цэвэр дүн	Даатгалын нөөц сан	Давхар даатгагчид ногдох	Цэвэр дүн
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан	12,674,393	(2,607,873)	10,066,520	8,696,392	(1,431,797)	7,264,595
Учирсан боловч мэдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС)	1,251,016	(65,080)	1,185,936	1,433,186	(18,319)	1,414,867
Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС)	2,724,132	(436,118)	2,288,014	1,158,637	(348,679)	809,958
Учирч болзошгүй хохирлын нөөц сан	184,164	-	184,164	530,247	-	530,247
	16,833,705	(3,109,071)	13,724,634	11,818,462	(1,798,795)	10,019,667

Нөөц сангүүдийн өөрчлөлтийг дараах байдлаар харуулав:

	Даатгалын нөөц сан (мянган төгрөгөөр)		Давхар даатгагчид ногдох (мянган төгрөгөөр)			
	2024 оны 1 сарын 1	Нөөц сангийн өөрчлөлт	2024 оны 12 сарын 31	2024 оны 1 сарын 1	Нөөц сангийн өөрчлөлт	2024 оны 12 сарын 31
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	8,696,392	3,978,001	12,674,393	(1,431,797)	(1,176,076)	(2,607,873)
Учирсан боловч мэдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС)	1,433,186	(182,170)	1,251,016	(18,319)	(46,761)	(65,080)
Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС)	1,158,637	1,565,495	2,724,132	(348,679)	(87,439)	(436,118)
Учирч болзошгүй хохирлын нөөц	530,247	(346,083)	184,164	-	-	-
	11,818,462	5,015,243	16,833,705	(1,798,795)	(1,310,276)	(3,109,071)

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

	Даатгалын нөөц сан (мянган төгрөгөөр)			Давхар даатгагчид ногдох (мянган төгрөгөөр)		
	2023 оны 1 сарын 1	Нөөц сангийн өөрчлөлт	2023 оны 12 сарын 31	2023 оны 1 сарын 1	Нөөц сангийн өөрчлөлт	2023 оны 12 сарын 31
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	6,768,782	1,927,610	8,696,392	(2,540,883)	1,109,086	(1,431,797)
Учирсан боловч мэдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС)	1,824,491	(391,305)	1,433,186	(62,440)	44,121	(18,319)
Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС)	2,693,863	(1,535,226)	1,158,637	(713,148)	364,469	(348,679)
Учирч болзошгүй хохирлын нөөц сан	459,362	70,885	530,247	-	-	-
	11,746,498	71,964	11,818,462	(3,316,471)	1,517,676	(1,798,795)

Орлогод тооцоогүй хураамжийн нөөц санг дараах байдлаар харуулав:

	2024 оны 12 дугаар сарын 31 (мянган төгрөгөөр)			2023 оны 12 дугаар сарын 31 (мянган төгрөгөөр)		
	Даатгалын нөөц сан	Давхар даатгагчид ногдох	Цэвэр дүн	Даатгалын нөөц сан	Давхар даатгагчид ногдох	Цэвэр дүн
1 сарын 1-ээрх	8,696,392	(1,431,797)	7,264,595	6,768,782	(2,540,883)	4,227,899
Тайлант хугацаанд бүртгэгдсэн хураамж	27,179,123	(2,861,006)	24,318,117	16,086,754	(2,861,006)	13,225,748
Тайлант хугацаанд орлогод тооцсон хураамж	(23,201,122)	1,684,930	(21,516,192)	(14,159,144)	3,970,092	(10,189,052)
12 сарын 31-ээрх	12,674,393	(2,607,873)	10,066,520	8,696,392	(1,431,797)	7,264,595

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

25. Холбоотой талын ажил гүйлгээ ба үлдэгдлүүд

2024 оны 12 сарын 31-нээрх болон 2023 оны 12 сарын 31-нээрх холбоотой талуудын үлдэгдлийг харуулав:

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Өр төлбөр:		
Мандал Ассет Менежмент ХХК*	37,500	25,500
Мандал Фьючур Гроут ХОС ХХК**	8,272,713	1,764,342
Мандал Даатгал ХК**	1,533,728	847,780
ТИБИ Дайтус ХХК**	200,600	-
Нийт дүн	10,044,541	2,637,622

Хувьцаа эзэмшигч компани (*)

Нийтлэг хяналтад байдаг бусад холбоотой тал (**)

Тайлант жилийн холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээг дараах байдлаар харуулав:

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Үйл ажиллагаа зардал:		
Мандал Ассет Менежмент ХХК*	150,000	102,000
Мандал Санхүүгийн Нэгдэл ХХК**	300,000	150,000
Мандал Лайф ХХК**	320	16,930
Нийт дүн	450,320	268,930
Санхүүгийн хөрөнгө оруулалт:		
Мандал Фьючур Гроут ХОС ХХК**	6,508,371	1,764,342
Мандал Даатгал ХК**	685,948	847,780
ТИБИ Дайтус ХХК**	200,600	-
Нийт дүн	7,394,919	2,612,122

Холбоотой талуудын хоорондын гүйлгээнүүд нь харилцан тохиролцсоны үндсэн дээр хийгдсэн байх бөгөөд тайлант хугацааны эцсийн үлдэгдэл нь барьцаагүй, хүүгүй ба эргэн төлөлт нь 30 хоногийн дотор барагдуулах нөхцөлтэй байдаг. Шимтгэлийн хувь нь бусад үйлчлүүлэгчдэд санал болгосон шимтгэлийн зардалтай ижил байсан.

Тайлант хугацаан дахь захирлууд болон бусад гол удирдах ажилтнуудын цалин дараах байдалтай байсан:

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Тайлант жилийн цалин, урамшуулал	824,223	819,036



ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

26. Эрсдлийн удирдлагын бодлого

26.1 Удирдлагын бодлого

Компанийн санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Компанийн зээл, хүү болон валютын ханш, хөрвөх чадварын эрсдэлүүдийг удирдаж эдгээр эрсдэлийн Компанийн үр дүнд сергэөр нөлөөлөх боломжит нолоог багасгахын зэрэгцээ Компанийн хөгжлийг дэмжих санхүүгийн хүрэлцэхүйц баялагтай байх явдлыг баталгаажуулахыг зорьдог.

Компани нь Төлөөлөн Удирдах Зөвлөл болон түүний дэргэдэх хороод болон удирдлагын хорооноос батлагдсан эрсдэлийн удирдлагын бодлоготой. Энэ бодлого нь Компанийн бүтэц болон төлөөлөн удирдах зөвлөлөөс эхлээд удирдлагын хороо ба ахлах албан тушаалтнуудын үүрэг болон томилолтыг баримтжуулснаар дэмжигддэг болно.

26.2 Капиталын удирдлага

Компанийн хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь тасралтгүй үйл ажиллагааг явуулах чадварыг ханган ажиллах, бизнесийн цаашдын үйл ажиллагааг дэмжихийн тулд өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хадгалах болон хувьцаа эзэмшигчдийн Хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршдог.

Компани нь капитал болон өөрийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд толилуулсны дагуу удирддаг ба Монголын Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ноос тогтоосон өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангах үүднээс Компанийн капиталыг тодорхой түвшинд хадгалж ажилладаг.

Компани өөрийн хөрөнгийн бутцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдал болон үйл ажиллагааных нь эрсдэлийн шинж чанарт орсон өөрчлөлтүүдийг харгалzan капиталын бүтцэд залруулга хийдэг байна. Компани капиталынхаа бүтцээ хадгалах эсвэл тохируулахын тулд хувьцаа эзэмшигчдэд төлөх ногдол ашгийн хэмжээг тохируулах, тэдний хөрөнгийг нь эргүүлэн төлөх эсвэл шинээр энгийн хувьцаа гаргадаг байна. 2024 оны 12 сарын 31-ний байдлаар Компанийн капиталын удирдлагын зорилт болон бодлого, үйл явцад өөрчлөлт гараагүй болно.

Компани нь капитал болон өөрийн хөрөнгийг СЗХ болон Монгол улсын даатгалын тухай хуульд заасны дагуу хөрөнгө болон өр төлбөртөө дансны үнийн тохируулга хийдэг. СЗХ-ны хөрөнгийн шаардлага нь Компанийн бизнесийн мэдээллийг зохих томъёонд оруулснаар тодорхойлогддог.

26.3 Захиргааны удирдлага

Компани нь өөрийн үйл ажиллагаагаа эрхэлж буй эрх зүйн хууль дүрэмд захирагдана. Энэхүү дүрэм нь зөвхөн зөвшөөрөл олгох болон үйл ажиллагаанд хяналт тавихаас гадна өөр нөхцөлүүдээр (жишээлбэл: төлбөрийн чадварын тооцоолол) хязгаарлалт тавьж ажилладаг нь өр төлбөрийн болон татан буугдах эрсдэлүүдийг багасгах, даатгалын компаниудыг тооцоолоогүй өр төлбөрөө тухайн үед нь төлөх чадвартай байдлыг хангах зорилготой болно.

Санхүүгийн чадал, өөрийн өмч, төлбөрийн чадварыг тайлагнаадаа СЗХ-оос баталсан дүрмийн дагуу тооцоолно. Эдгээр хөрөнгийн шалгуурууд нь байх ёстой төлбөрийн чадвар, өмч болон бизнесийн онцлогийг тусгасан зохистой үнэлэмжүүд дээр үндэслэгддэг болно.

Компанийн даатгалын бизнестээ баримталдаг капиталын удирдлагын бодлого нь СЗХ-ны тогтоол дээр үндэслэн заавал байлгах ёстой болон бусад нэмэлтээр шаардлагатай хөрөнгийг эзэмших явдал юм.

2024 оны тайлант жилийн туршид Компани эдгээр бүх шаардлагуудыг хангаж ажилласан.



ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

27. Даатгалын болон санхүүгийн эрсдэл

27.1 Даатгалын эрсдэл

Даатгалын эрсдэл гэж аль нэг даатгалын гэрээ хийгдсэнтэй холбоотойгоор урган гарч болох тухайн даатгуулсан уйл явдал болон нөхцөл байдлыг ойлгох ба үүнээс болж тодорхой бус хэмжээний алдагдал хүлээн зөвшөөрөх боломжтой эрсдэлийг хэлнэ. Даатгалын гэрээний үндсэн мөн чанар нь тухайн эрсдэл тохиолдлын шинжтэй тул урьдчилан таамаглах боломжгүй юм.

Компанид даатгалын гэрээнүүдийн улмаас тулгарч буй гол эрсдэл нь төлөгдсөн нөхөн төлбөр болон цаг хугацааны хувьд тооцоолсноос зөрөх явдал юм. Энэ эрсдэл нь нөхөн төлбөрийн давтамж, ноцтой байдал, төлсөн төлбөр ба урт хугацаат нөхөн төлбөрийн нэмэлт хөгжлөөс хамааралтай байдаг. Тиймээс, Компанийн зорилго нь эдгээр өр төлбөрүүдийг барагдуулах хангалттай санг байлгах юм.

Хөрөнгийн болон хариуцлагын даатгалтай холбоотойгоор урган гарч болох болзошгүй томоохон нөхөн төлбөрүүд нь Компанийн мөнгөн гүйлгээ болон үр дүнгийн үзүүлэлтүүдэд бодитой нөлөө үзүүлж чадахуйц гол хүчин зүйл юм. Түүнчлэн Компанийн бизнесийн үйл ажиллагаа нь зөвхөн Монголд төвлөрдөг. Энэ нь Компанийн даатгалын багц дахь эрсдэлүүд нь газар зүйн хувьд нэг байршилд төвлөрсөн байгааг харуулж байна. Үүнээс үндэслэн өнгөрсөн дэх адил төстэй эрсдэлүүдээс үссэн нөхцөл байдал болон түүхэн алдагдлын давтамж дээр суурилсан даатгалын эрсдэлийн төвлөрлийг зохицуулах оновчтой болоод зохистой давхар даатгалын хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор Компани нь давхар даатгалын хамгаалалтын менежментийн бодлогыг сонгон авч ажиллаж байна.


Компанийн давхар даатгалын хамгаалалтын менежментийн бодлогын зорилгод хувьцаа эзэмшигчдийн өмчийг хамгаалах, Компанийн даатгалын үйл ажиллагааны үр дүнгээс үсэж болох тогтвортой байдлыг намжаах, Компанид өрсөлдөхүйц давуу тал бий болгох, тогтвортой болоод олон талт давхар даатгалын баталгааг санал болгох болон урт хугацааны стратегийн түншлэлийг гол давхар даатгагчидтай бэхжүүлэн хөгжүүлэх зэрэг зүйлс багтдаг. Тайлант хугацааны эцэс бүрд удирдлага давхар даатгагчдад төлбөрийн чадварын үнэлгээ хийж давхар даатгалын худалдан авалтын стратегийг шинэчлэн боловсруулдаг ба үүгээрээ давхар даатгалын хөрөнгө дэх үнэ цэнийн бууралтыг тогтоох боломжтой. Даатгалын нөөц сангийн дэлгэрэнгүйг Тодруулга 24-ыг харна уу.

27.1.1 Ердийн даатгалын гэрээнүүд

Компани дараах төрлүүдийн ердийн даатгалын гэрээг олгодог болно, үүнд: гэнэтийн осол эмчилгээний, Хөрөнгийн, тээврийн хэрэгслийн, ачааны, барилга угсралтын, хариуцлагын болон санхүүгийн даатгал орно. Ердийн даатгалууд нь ихэнхдээ 12 сарын хугацаанд эрсдэлийг даатгадаг.

Эдгээр даатгалын гэрээнүүдийн хамгийн том эрсдэлүүд нь эд хөрөнгийн хохирол, санхүүгийн алдагдал, үхэл гэх мэт урьдчилан таамаглах боломжгүй эрсдэлүүд ордог.

Дээрх эрсдэлүүдийг нь даатгалын гэрээний их хэмжээний багцыг хэт төвлөрүүлэхгүй байх замаар багасгадаг. Эргэцүүлэл болон сонгон шалгаруулалтаар эрсдэлийн ялгаатай байдлыг сайжруулж, андеррайтерийн стратегийг хэрэгжүүлдэг нь эрсдэлийн төрлүүд болон даатгуулагчийн авч буйг өгөөжийн түвшний хувьд эрсдэлийг төрөлжүүлсэн байх явдлыг хангахад чиглэгдсэн ба энэ нь салбаруудын төрөлжүүлэлт, хэт төвлөрөлгүй байх бодлогоор хангагддаг. Цаашлаад, шинэ болон одоогоор хянагдаж байгаа бүх нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг үнэлэх, нэхэмжлэлийн хяналтыг тогтмол хянаж, залипан мэхлэх боломжтой нэхэмжлэлийг байнга нягтлан шалгах нь Компанийн эрсдэлд өртөх эрсдэлийг багасгах бодлого, журамд орсон байдаг. Компани цаашдаа бизнесийг сөргөөр хүргэж болох ирээдүйд гарах урьдчилан таамаглах боломжгүй эрсдэлийг бууруулахын тулд нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг түргэн шуурхай шийдвэрлэх бодлого хэрэгжүүлдэг.



ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Дараах хүснэгтэд даатгалын нөөц сангуудыг даатгалын хэлбэрийн хувьд шинжлэв:

Даатгалын тэрээний төрөл	2024 оны 12 дугаар сарын 31 (мянган төгрөгөөр)			2023 оны 12 дугаар сарын 31 (мянган төгрөгөөр)		
	Даатгалын нөөц сан	Давхар даатгагчид ногдох	Цэвэр дүн	Даатгалын нөөц сан	Давхар даатгагчид ногдох	Цэвэр дүн
Хөрөнгө	3,229,968	(1,074,446)	2,155,522	2,125,061	(740,413)	1,384,648
Тээврийн хэрэгсэл	7,951,743	-	7,951,743	5,593,628	-	5,593,628
Жолоочийн хариуцлага	799,141	(5,050)	794,091	1,421,106	(4,643)	1,416,463
Гэнэтийн осол, эмчилгээ	2,110,068	(75,610)	2,034,458	1,063,069	(74,990)	988,079
Хариуцлага	1,213,432	(527,897)	685,535	955,606	(387,292)	568,314
Санхүү	719,705	(656,747)	62,958	535,114	(533,840)	1,274
Ачаа	107,608	(67,354)	40,254	116,144	(57,617)	58,527
Барилга угсралт	702,040	(701,967)	73	4,828	-	4,828
Зээл	-	-	-	3,906	-	3,906
Мал амьтад	-	-	-	-	-	-
Итгэлцэл	-	-	-	-	-	-
Нийт дүн	16,833,705	(3,109,071)	13,724,634	11,818,461	(1,798,795)	10,019,667

27.1.2 Гол төсөөллүүд


Өр төлбөрийн тооцооллын үндсийг бүрдүүлж буй гол төсөөллүүд нь Компанийн ирээдүйн нөхөн төлбөрүүд нь өмнөх жилүүдтэйгээ ижил хэлбэрээр үүсэхэд тулгуурлана. Үүнд, дундаж нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарах зардал, нөхөн төлбөртэй холбоотой инфляцийн нөлөө болон тохиолдлын жилд гарсан нөхөн төлбөрийн тоо хэмжээ ордог.

Нэмэлтээр тоон бус үнэлэмжүүд аль өмнөх жилийн хандлага нь ирээдүйд хамааралгүйг дүгнэнэ, жишээлбэл: зөвхөн нэг удаагийн тохиолдлууд, олон нийтийн нөхөн төлбөрийг гарах хандлага, эдийн засгийн байдал гэх мэт зах зээлийн хүчин зүйлүүдээс гадна дотоод хүчин зүйлүүд болох бүтээгдэхүүний төрлүүд, журмын нөхцөлүүд ба нөхөн төлбөрийн үйл ажиллагаанууд орно. Энэхүү үнэлэмж нь гаднаас ирж буй нөлөөлөл болох шүүхийн шийдвэр болон засгийн газраас гаргасан хууль нь хэрхэн тооцоололд өөрчлөлт оруулахыг мөн шалгана.

Гол төсөөллүүд нь өөр байхад хүүгийн түвшин, төлбөр тооцооны saat албан ёсны гадаад валютын ханшийн зөрүү нөлөөлнө. Тооцооллын явцад тодорхойгүй байдлын улмаас эцсийн алдагдлын харьцаанаас өөр хувьсагчийн мэдрэмжийг итгэл үнэмшилтэйгээр тоон байдаар илэрхийлэх боломжгүй байсан.

27.1.3 Мэдрэмж

Гол төсөөллүүдээс бусад бүх төсөөллүүд нь тогтмол гэж үзвэл, гол төсөөлөлд гарах боломжтой өөрчлөлтүүд нь нийт болон цэвэр өр төлбөр, татварын өмнөх ашиг болон өөрийн хөрөнгөнд хэрхэн нөлөөлөхийг дараах хүснэгт үзүүлнэ.



ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Төсөөллүүдийн хоорондын уялдаа нь эцсийн нөхөн төлбөрийн өглөгийг тооцоолоход томоохон нөлөөлөл үзүүлэх боловч, төсөөллийн өөрчлөлтийн нөлөөллийг үзүүлэхийн тулд, тус бүрд нь өөрчлөх шаардлагатай. Эдгээр төсөөллүүдийн өөрчлөлт нь шугаман бусаар өөрчлөгдж байгаа болно. Төсөөллүүдийн мэдрэмж нь эдийн засгийн өнөөгийн үзүүлэлтүүд, ихэвчлэн опцион болон баталгааны уламжлалт өртөг болон цаг хугацааны үнэ цэнийн өөрчлөлтийн нөлөөллөөс хамаарна.

Мэдрэмжийн дүн шинжилгээг хийхэд давхар даатгалд ногдох бүх нөхөн төлбөрүүд нь буцаан олгогдоохоор төсөөлөгдсөн. Ялангуяа нөхөн төлбөрийн нөөц сангийн 10% -аар өссөн гэж тооцвол гэрээгээр тохиролцсон давхар даатгагчид ногдох нөхөн төлбөр ч мөн адил хувиар өссөн дүнгээр нэмэгдэн буцаан олгогдоохоор төсөөлөгдсөн болно.

2024	Дундаж төлбөрийн зардлын өөрчлөлт	Нийт нөөц сангийн өсөлт / (бууралт) (мян.төг)	Цэвэр нөөц сангийн өсөлт / (бууралт) (мян.төг)	Татварын өмнөх ашгийн өсөлт / (бууралт)	*Эдийн өсөлт / (бууралт) (мян.төг)
Мэдрэмж	+ 10%	415,931	365,811	(365,811)	(329,230)
	- 10%	(415,931)	(365,811)	365,811	329,230
2023	Дундаж төлбөрийн зардлын өөрчлөлт (%)	Нийт нөөц сангийн өсөлт / (бууралт) (мян.төг)	Цэвэр нөөц сангийн өсөлт / (бууралт) (мян.төг)	Татварын өмнөх ашгийн өсөлт / (бууралт) (мян.төг)	*Эдийн өсөлт / (бууралт) (мян.төг)
Мэдрэмж	+ 10%	312,207	275,507	(275,507)	(247,956)
	- 10%	(312,207)	(275,507)	275,507	247,956

*Өөрийн хөрөнгөнд үзүүлэх нөлөөг харуулахдаа татварын нөлөөллийг оролцуулан тооцсон.

27.1.4 Санхүүгийн эрсдлүүд

Компанийн гол санхүүгийн хэрэгслүүд нь үйл ажиллагааны авлага, урьдчилж гарсан зардал, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, богино хугацаат хадгаламж, давхар даатгагчид өгөх өглөг болон бусад өглөгөөс бүрдэнэ.

Компанийн эдгээр санхүүгийн хэрэгслүүдээс үүсэж буй гол эрсдэлүүд нь төлбөрийн чадварын, хүүгийн түвшний, хөрвөх чадварын болон гадаад валютын эрсдэл юм. Компанийн удирдлагын эрсдэлүүдэд тавьдаг хяналтууд болон баталсан бодлогуудыг дараах байдлаар нэгтгэн үзүүлэв.

27.1.5 Төлбөрийн чадварын эрсдэл

Төлбөрийн чадварын эрсдэл гэдэг нь нэг тал санхүүгийн хэрэгсэлд хамаатай үүрэг хариуцлагаа нөгөө талд шилжүүлж чадахгүй болсноос болж нөгөө тал санхүүгийн алдагдал хүлээх эрсдэл юм. Компани голдуу банкин дахь мөнгө, хугацаат хадгаламж, даатгуулагчдаас авах даатгалын хураамжийн авлагууд болон давхар даатгагчдаас авах авлагуудаас төлбөрийн чадварын эрсдэлд өртөх боломжтой.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Компани нь төлөөлөн удирдах зөвлөл болон удирдлагын зүгээс зах зээл дээр эзлэх байр суурь болон төлбөрийн чадвар сайн гэж үнэлэгдсэн банкнуудад мөнгөн хөрөнгөө байршуулдаг. Үүнтэй адил Компани нь зөвхөн удирдлагаар үнэлэгдсэн хангалттай төлбөрийн чадвар болон нэр хүндтэй давхар даатгалын компаниудтай хамтарч ажилладаг.

Зээлийн эрсдэлийн удирдлага.

Зээлийн эрсдэл нь Компанийн бизнесийн хамгийн том эрсдэл юм; Тиймээс удирдлага нь зээлийн эрсдэлийг болгоомжтойгоор удирддаг.

Эрсдэлийн удирдлагын зорилгоор зээлийн эрсдэлийн тооцоолол нь нарийн төвөгтэй бөгөөд эрсдэл нь зах зээлийн нөхцөл байдал, хүлээгдэж буй мөнгөн урсгал, цаг хугацаа зэргээс хамааран өөр өөр байдаг. Зээлийн багцад зориулсан эрсдэлийн үнэлгээ нь дефолт болох магадлал, алдагдлын харьцаа болон холбоотой талуудын хоорондын дефолт болох уялдааг тооцоолох шаардлагатай байдаг.

Хязгаарууд. Компани нь нэг зээлдэгч, холбоотой талууд, салбарын төвлөрөлтөд хүлээн зөвшөөрөгдсөн эрсдэлийн хэмжээг тогтоох замаар зээлийн эрсдэлийн түвшинг тогтоодог. Бүтээгдэхүүн болон эдийн засгийн салбарын зээлийн эрсдэлийн түвшний хязгаарлалтыг удирдлагын зүгээс байнга баталж байдаг. Эрсдэлийг жил тутам эргэн хянадаг ба шаардлагатай тохиолдолд илүү ойрхон давтамжтайгаар хянадаг.

Зээлийн эрсдэлийн үнэлгээний систем. Зээлийн эрсдэлийг үнийн дунгээр нь санхүүгийн хэрэглүүрийг үнэлэх болон зээлийн эрсдэлийг хэмжихийн тулд Компани нь хөндлөнгийн олон улсын үнэлгээний байгууллагуудын (Мүүди'с, Стандард энд Пүүрс-“S&P”, Фитч) гаргасан эрсдэлийн үнэлгээг үндэслэсэн аргачлалыг ашигладаг. Гадны болон дотоодын зээлийн үнэлгээг дотооддоо бий болгосон дефолт болох магадлалын тодорхойлогдсон үнэлгээтэй уялдуулан дараах байдаар тооцоолдог:

Зээлийн эрсдэлийн үнэлгээний систем	Дотоод үнэлгээний харгалзах зэрэг
Маш сайн	AAA TO BB+
Сайн	BB TO B+
Хангалттай	B, B-
Тусгай хяналттай	CCC TO CC-
Дефолт буюу төлбөр төлөгдөхгүй болох	C, D-I, D-II

Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр бүрээр зээлжих чадварын зэргийг дараах байдлаар тодорхойлсон:

- Маш сайн - хүлээгдэж буй зээлийн эрсдэл багатай, чанартай зээл;
- Сайн - дунд зэргийн зээлийн эрсдэлтэй, зээлийн чанар хангалттай;
- Хангалттай — хангалттай зээлийн эрсдэлтэй, зээлийн чанар дунд зэрэг;
- Тусгай хяналттай — удирдлага илиш ойр ойрхон хяналт тавьж, арга хэмжээ авах шаардлагатай;
- Төлбөрийн чадваргүй болох— төлбөрийн чадваргүй болсон хэрэгслүүд.

Харилцагч байгууллагуудыг үнэлэхдээ хөндлөнгийн олон улсын үнэлгээний агентлагууд болох Стандард энд Пүүрс, Мүүди'с, Фитч-ээс гаргасан үнэлгээг ашигласан. Эдгээр үнэлгээнүүд нь олон нийтэд нээлттэй байдаг. Эдгээр үнэлгээнүүд болон дефолт буюу төлбөрийн чадваргүй болох магадлалын харгалзах хүрээ нь өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт (Засгийн газрын болон Компанийн бонд) зэрэг санхүүгийн хэрэглүүрүүдэд хэрэглэгдсэн.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Дараах хүснэгтээр Компанийн харилцах банкуудын үнэлгээг харуулав:

Харилцах банк	Ажил гүйлгээ	Үнэлгээний агентлаг	Үнэлгээ
Хаан Банк ХХК	Харилцах данс, хугацаат хадгаламж	Фитч	В
Төрийн Банк ХХК	Харилцах данс, хугацаат хадгаламж	Фитч	В
Хас Банк ХХК	Харилцах данс, хугацаат хадгаламж	Фитч	В
Капитрон Банк ХХК	Харилцах данс, хугацаат хадгаламж	Фитч	В
Худалдаа Хөгжлийн Банк ХХК	Харилцах данс	Фитч	В
Голомт Банк ХХК	Харилцах данс	Фитч	В
Ариг Банк ХХК	Харилцах данс	Фитч	В
Богд Банк ХХК	Харилцах данс	Фитч	В
Эм Банк ХХК	Харилцах данс	Фитч	В

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын хэмжилт

ХБЭА нь ирээдүйд хүлээж болзошгүй мөнгөний алдагдлын өнөөгийн үнэ цэнийг магадлалын үндсэн дээр жинлэсэн тооцоолол (өөрөөр хэлбэл: зээлийн үргэлжлэх хугацаанд зээл төлөгдөхгүй болоход эрсдэлээр жинлэсэн дундаж алдагдал) юм. ХБЭА нь нэг хүчин зүйлээс шууд хамааралтай бус хэд хэдэн боломжит хувилбаруудаас хамаарч тооцоологддог. Компанийн ХБЭА—ын тооцоолол дөрвөн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд: Дефолт/ Төлбөр төлөгдөхгүй болох магадлал ("PD"), Дефолт/Төлбөр төлөгдөхгүй болох үеийн үлдэгдэл ("EAD"), Дефолт болсон тохиолдолд хулээх алдагдлын хэмжээ/ Алдагдал үүсэх магадлал ("LGD") болон хорогдуулалтын хувь ("DR").

EAD гэдэг нь төлбөр төлөгдөхгүй болох үеийн үлдэгдэл бөгөөд тайлант хугацаанаас хойших төлбөрийн үлдэгдлийг таамаглахдаа зээлийн эргэн төлөлт буюу үндсэн зээлийн болон хүүгийн төлөлт, нэмж олгож болзошгүй зээлийн дүнг харгалзан авч үздэг. Хүлээж болзошгүй үүргийн биелэгдэхгүй болох үеийн зээлийн үлдэгдлийг тооцоолохдоо зээл хөрвүүлэлтийн коэффициент ("CCF") ашигладаг.

CCF нь хүлээж болзошгүй үүрэг зээл хөрвүүлэлтийн магадлалын коэффициент юм. Компани хүлээж болзошгүй үүрэг 12 сарын дотор зээл рүү хөрвөх болон дуусах хугацааны турш зээл хөрвүүлэлтийн магадлалуудыг адил гэж үзсэн. PD нь егөгдсөн хугацааны туршид төлбөр төлөгдөхгүй болох магадлалын тооцоолол юм. LGD нь зээл/төлбөр төлөгдөхгүй болсон тохиолдолд түүнээс хүлээж болзошгүй алдагдлын тооцоолол юм. LGD нь гэрээний дагуух төлөх ёстой мөнгөн дүн болон зээлдүүлэгч тухайн зээлээс төлүүлж чадах мөнгөн дүн хоёрын зөрүү юм. Харилцагчаас төлүүлж чадах мөнгөн дунд барьцаа хөрөнгө орно. LGD нь ихэвчлэн EAD—д эзлэх хувиар илэрхийлэгддэг. Хүлээгдэж буй алдагдлыг тайлант хугацааны эцэст өнөөгийн үнэ цэнээр хорогдуулна. Хорогдуулалтын хувь нь санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн түвшин ("EIR") юм.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын хугацааны турш загварчилсан ба ашиглалтын хугацаа гэдэг нь өрийн хэрэглүүрийн гэрээний дагуух үлдсэн хугацаа (хэрэв төлөлт хийгдсэн бол түүнийг тохируулсан хугацаа) юм. Зээлийн үүрэг болон санхүүгийн баталгааны гэрээний хувьд энэ нь тухайн байгууллага зээлийг сунгахад гэрээгээр хүлээсэн үүрэгтэй байгааг илтгэдэг гэрээний хугацаа юм.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Удирдлага нь хугацааны турш хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг загварчилдаг ба энэ нь санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын үлдэх хугацааны туршид үүсэж болзошгүй бүх тохиолдлоос үүсэх алдагдал юм. 12 сарын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь тайлагнالын өдрөөс хойш 12 сарын дотор эсвэл Санхүүгийн хэрэглүүрийн үлдэх хугацаа нь нэг жилээс бага байгаа бол санхүүгийн хэрэглүүрт тохиолдох болзошгүй үйл явдлаас үүсэх ба ашиглалтын хугацааны хүлээгдэж буй зээлийн алдагдлын нэг хэсгийг илэрхийлнэ.

Эдгээр санхүүгийн тайлангийн зорилгоор удирдлагаас үнэлдэг ХБЭА нь зохицуулалтын зорилгоор ихэвчлэн ашиглагддаг мөчлөгийн тооцоолол гэхээс илүү тухайн цаг хугацааны тооцоолол байдаг. Тооцоололд ирээдүйд чиглэсэн мэдээллийг буюу зээлийн эрсдэлд нөлөөлөх макро эдийн засгийн гол хувьсагчдын жинлэсэн магадлалын дунг ХБЭА-д тусгасан эсэхийг авч үздэг.

Дараахаас бусад тохиолдолд үнэ цэнийн бууралттай байх үед нь худалдан авсан эсвэл үнэ цэнийн бууралттай шинээр гаргасан ("POCI") санхүүгийн хөрөнгүүдийн ХЭА-ын загварчлал нь ялгаатай байдаггүй: (а) гэрээт мөнгөн урсгалд суурилсан гэхээс илүүтэйгээр хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрөх үед нөхөн олгосон мөнгөн урсгалд суурилсан хөрөнгийн дансны нийт үнэ ба хөнгөлөлтийн хувь хэмжээ (б) ХБЭА нь үргэлж ашиглалтын хугацааны турш дахь ХБЭА байдаг. POCI хөрөнгө гэдэг нь өмнөх бизнесийн нэгдлийн явцад олж авсан үнэ цэнийн бууралттай зээл гэх мэт анхны хүлээн зөвшөөрөлтөөр үнэ цэнэ нь буурсан санхүүгийн хөрөнгийг хэлнэ.

Компани дефолт болох магадлалыг тооцоолоходоо доор дурдсан нөхцөлүүдийн аль нэгийг эсвэл хэд хэдэн нөхцөлийг зэрэг хангасан зээлийг дефолт болсон гэж үздэг. Үүнд:

- Зээл төлөгдөхгүй байх: Доорх нөхцөлүүд илэрсэн тохиолдолд зээлийн төлөгдөхгүй байх магадлал ихэсдэг
 - гаргагч эсвэл зээлдэгч санхүүгийн хүндрэлд орсон;
 - гэрээний нөхцөл зөрчигдсөн буюу хүүгийн болон үндсэн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн;
 - зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй холбоотой эдийн засаг, эрх зүйн шалтгаанаар зээлдэгч зээлдүүлэгчид концесс олгох;
 - зээлдэгч дампуурлаа зарлах буюу санхүүгийн дахин зохион байгуулалт хийх магадлалтай байх;
 - санхүүгийн хүндрэлээс болж Санхүүгийн хөрөнгийн хувьд идэвхтэй зах зээл байхгүй болох; эсвэл
- Зээлдэгч нь 90 хоногоос дээш хугацаагаар гэрээний төлбөрөө төлөөгүй.

Тодруулгын зорилгоор, Компанийн дефолтын тодорхойлолт болон хөрөнгийн үнэ цэнэ бууралтын тодорхойлолт хооронд ямар нэгэн зөрүүгүй бөгөөд дээр дурдсан дефолт тодорхойлолт нь Компанийн Санхүүгийн бүх хөрөнгөнд мөрдөгднө. Хэрэглүүр нь 3 сарын дараалан дефолт тодорхойлолтонд заасан нөхцөлүүдийг хангаагүй тохиолдолд дефолтоос гарч болно. 3 сар гэдэг нь санхүүгийн хэрэглүүр дефолтоос гарсан хөрөнгө буцаж дефолт болсон хугацааны тооцоололд үндэслэн гарсан болно.

Анхлан хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн (SICR) эсэх үнэлгээ нь зээл нэг бүрчлэн хийгддэг. Компанийн холбогдох удирдлагууд зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэх шалгур нөхцөлүүдийн тохиромжтой байдлыг тогтмол хугацаатай хянаж байдаг.

Зээл анх олгогдоноос хойш эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэх шалгууруудын нэг болох хугацаа хэтэрсэн хоног нь 30 хоногоос дээш байх нөхцөл өөрчлөгдөөгүй болно.

Компани нь нэг эсвэл түүнээс олон тоон болон чанарын шалгуур үзүүлэлтүүдийг хангасан тохиолдолд санхүүгийн хэрэглүүрийг SICR-тэй (Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт) гэж үздэг.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Компанийн харилцагчдын гаргасан бондын хувьд:

- 30 хоногоос дээш хугацаа хэтэрсэн;
- “Тусгай хяналттай” гэсэн эрсдэлийн үнэлгээтэй болсон; Дансны болон бусад авлагын хувьд;
- 30 хоногоос дээш хугацаа хэтэрсэн;

Энэхүү санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн ХБЭА-ын түвшин нь бонд гаргагчийн зээлийн эрсдэл анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц өссөн байгаа эсэхээс хамаарна. Энэ нь ХБЭА-ын хэмжилтийн 3-шатлалт загвар болно. Анхны хүлээн зөвшөөрөлтөөр зээлийн үнэ цэнэ буураагүй мөн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гаралаагүй санхүүгийн хэрэглүүрийг 12 сарын ХБЭА (1-р шатлал)-д үндэслэн эрсдэлийн алдагдлын нөөц санг байгуулна. Хэрэв анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш SICR гарсан бол санхүүгийн хэрэглүүрийг 2-р шатлалд шилжүүлэх боловч зээлийн үнэ цэнэ хараахан буураагүй бөгөөд эрсдэлийн санг ХБЭА-ын ашиглалтын хугацаанд үндэслэн байгуулна.

Хэрэв санхүүгийн хэрэглүүрийн зээлийн үнэ цэнэ буурсан бол 3-р шатлалд шилжүүлэх бөгөөд эрсдэлийн санг ХБЭА-ын ашиглалтын хугацаанд үндэслэн байгуулна. Хөрөнгө 3-р шатлалд байснаар нийт дансны үнэд сууринсан хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрөхөө зогсоох бөгөөд хүүгийн орлогыг тооцоолоходоо ХБЭА-ыг хассан дансны үнэд хөрөнгийн үр ашигт хүүгийн аргаар тооцоолно.


Хэрэв SICR шалгуур хангагдахаа больсон гэдэг нь нотлогдсон бол хэрэглүүрийг 1-р шатлалд буцааж шилжүүлнэ. Чанарын үзүүлэлтээр үнийн дүнг 2-р шатлалд шилжүүлсэн бол Компани энэ үзүүлэлт хэвээр байгаа эсвэл өөрчлөгдсөн эсэхэд хяналт тавина.

Анхнаас нь үнэ цэнийн бууралттай байх үед нь худалдан авсан эсвэл үнэ цэнийн бууралттай шинээр гаргасан санхүүгийн хөрөнгүүдийн ХБЭА-ыг ашиглалтын хугацааных нь туршид хэмжинэ. Иймд Компани зөвхөн нийт хугацааны турш дахь ХБЭА-д гарсан хуримтлагдсан өөрчлөлтийг хүлээн зөвшөөрнө. Компани нь ХБЭА-ын хэмжилтийн хоёр аргатай: (i) бие даасан ганцаарчилсан үнэлгээ, (ii) багцад сууринсан үнэлгээ: зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүд (жишээ нь, PD, LGD) нь адилхан бөгөөд хөрөнгө оруулалтын багцын ижил төрлийн сегментийн хувьд ХБЭА-ын тооцооллын явцад тэдгээрийг ашиглах болон (iii) гадны эх үүсвэрт сууринсан үнэлгээ. Компани дансны ба бусад авлагууд болон мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгүүдийн хувьд гадны хөндлөнгийн зэрэглэлд үндэслэн үнэлгээг хийдэг.

ХБЭА-ыг ганцаарчилсан байдлаар үнэлэхдээ янз бүрийн боломжит үр дагавар тус бүрийн магадлалыг харгалзан эрсдэлийн алдагдлыг тооцоолно. Компани үнэлэгдсэн бонд тус бүрийн хувьд дор хаяж хоёр боломжит үр дагаварыг тодорхойлсон бөгөөд эдгээр хувилбарын магадлал нь магадгүй маш бага байсан ч эрсдэлийн алдагдлыг бий болгодог.

ХБЭА нь дараах зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүдийн үржвэрүүдийн нийлбэр юм: дээр тайлбарласны дагуу тодорхойлогдсон төлбөр төлөгдөхгүй болсон үеийн дүн, төлбөр төлөгдөхгүй болох магадлал ба төлбөр төлөгдөхгүй болсон үеийн алдагдлын хэмжээ мөн хэрэглүүрүүдийн үр ашигт хүүний түвшинг ашиглан үнэлэх дискаунтчилсан дүнгийн нийлбэр юм. ХБЭА-ын хугацааны турш дахь эрсдэлийн параметрүүдийг (төлбөр төлөгдөхгүй болсон үеийн дүн - EAD, төлбөр төлөгдөхгүй болох магадлал - PD, төлбөр төлөгдөхгүй болсон үеийн алдагдлын хэмжээ - LGD) тусгайлсан болон багцын сегмент тус бүрийн хувьд ашиглалтын хугацааны туршид ирээдүйн жил бүрд тодорхойлдог.

Эдгээр гурван бүрэлдэхүүн хэсгүүдийг хооронд нь үржүүлж, оршин тогтоно магадлалыг тохируулна (жишээ нь, өмнөх саруудад төлөгдөөгүй эсвэл дахин төлөгдсөн дүнгүүд). Энэ нь ирээдүйн ХБЭА-ыг үр дүнтэйгээр тооцоолж дараа нь тайлангийн огноо руу буцаан дискаунтчилан нэгтгэдэг. ХБЭА-ын тооцоололд ашигласан дискаунтын түвшин нь анхны үр ашигт хүүний түвшин буюу түүнтэй ойролцоо дүн байна.



ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

27.1.6 Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь Компани өөрийн санхүүгийн өр төлбөрийг барагдуулах үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй болох эрсдэл юм. Компани нь хэвийн болон онцгой нэхцэлд их хэмжээний алдагдалд орохгүйгээр, Компанийн нэр хүндэд хохирол учруулах эрсдэлийг бий болгохгүйгээр өр төлбөрөө гэрээний хугацаанд төлж барагдуулахад хүрэлцэхүйц хөрвөх чадварыг байнга барьж байх ёстой гэдэг зарчмаар хөрвөх чадварыг удирдан зохицуулдаг.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хариуцдаг ба Компанийн богино, дунд ба урт хугацааны санхүүжилт болон хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын шаардлагад нийцсэн хөрвөх чадварын бүтцийг бий болгох үүрэгтэй. Компани санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн төлөгдөх хугацаа, банкнаас зээл авах чадавх, зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл, мөнгөн урсгалын таамаглал болон гүйцэтгэлд үндэслэн хөрвөх чадварын эрсдэлийг удирддаг. Хүснэгтэн дэх мэдээлэл нь Компанийн төлбөр төлөх шаардлагатай хамгийн эхний хугацаанд үндэслэсэн хорогдуулаагүй мөнгөн гүйлгээг харуулж байна.

2024 оны 12 дугаар сарын 31 (Мянган төгрөгөөр)	1 сараас доosh	1 сараас 3 сар хүртэлх	3 сараас 1 жил хүртэлх	1 жилээс дээш	Нийт
Нийт санхүүгийн хөрөнгө					
Дансны бусад авлага	694,568	6,637	165,374	-	866,577
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	97,918	-	-	-	97,918
Хугацаат хадгаламж	-	1,127,036	317,359	-	13,545,086
Бусад хөрөнгө оруулалт	10,494,950	2,245,984	18,500,485	3,036,329	34,277,748
	11,287,436	3,379,657	18,983,218	3,036,329	48,787,329
Санхүүгийн өөр төлбөр					
Хүүгүй*	(101,561)	(1,301,592)	(402,733)	-	(1,805,886)
	(101,561)	(1,301,592)	(402,733)	-	(1,805,886)
Цэвэр санхүүгийн хөрөнгө / (өөр төлбөр)	11,185,875	2,078,065	18,580,485	3,036,329	46,981,443

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2023 оны 12 дугаар сарын 31 (Мянган төгрөгөөр)	1 сараас доош	1 сараас 3 сар хүртэлх	3 сараас 1 жил хүртэлх	1 жилээс дээш	Нийт
Нийт санхүүгийн хөрөнгө					
Дансны бусад авлага	486,470	22,304	63,500	-	572,274
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	212,118	-	-	-	212,118
Хугацаат хадгаламж	-	1,117,584	7,580,109	-	8,697,693
Бусад хөрөнгө оруулалт	-	3,335,088	18,046,194	-	21,381,282
	698,588	4,474,976	25,689,803	-	30,863,367
Санхүүгийн өр төлбөр					
Хүүгүй*	(119,946)	(3,322)	(767,985)	-	(891,253)
	(119,946)	(3,322)	(767,985)	-	(891,253)
Цэвэр санхүүгийн хөрөнгө / (өр төлбөр)	578,642	4,471,654	24,921,818	-	29,972,114

* Хуулийн дагуу төлөх ёстой өр төлбөрийг оруулаагүй бөгөөд ирээдүйд төлөх хүүгийн өглөгийг оролцуулан тооцсон.

27.1.7 Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн урсгал хэлбэлзэх эрсдэлийг хэлнэ. Зах зээлийн эрсдэл нь турван төрлийн эрсдэлээс бүрдэнэ: гадаад валютын эрсдэл, хүүгийн түвшний эрсдэл болон зах зээлийн үнийн эрсдэл.

a. Гадаад валютын эрсдэл

Гадаад валютын эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэгслийн үнэ цэнэ гадаад валютын ханшийн сөрөг өөрчлөлтийн улмаас хэлбэлзэх эрсдэл юм. Компанийн гадаад валютын эрсдэл нь ихэвчлэн гадаадын давхар даатгалын компаниудаас хүлээн авсан мөнгө болон телсэн төлбөрүүдээс учирдаг. Мөн Компанийн гадаад валютын эрсдэл нь гадаад валютаар илэрхийлэгдсэн (ихэвчлэн ам.доллар) банкин дахь мөнгөн хадгаламж болон бусад өглөгүүдээс үүсдэг.

Даатгалын хураамжийн орлогын гүйлгээнүүд нь үйл ажиллагааны мөнгөн нэгж (төгрөг)-р хийгддэг учраас даатгалын үйл ажиллагаанаас үүдэн гарах гадаад валютын эрсдэлийн нөлөө бага юм. Компанид гадаад валютын эрсдэлийг зохицуулах албан ёсны бодлого болон журам байдаггүй.

Өөр бусад бүх хувьсагчид тогтмол байхаар тооцвол, тайлант жилийн эцсээрх гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс Компанийн үйл ажиллагааны мөнгөн нэгжид үзүүлэх нөлөөлөл ашиг, алдагдал болон өөрийн хөрөнгөнд хэрхэн нөлөөлөх талаар дараах хүснэгтэд үзүүлсэн.

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
+ 5% (2023: + 5%) – ам.доллар	7,209	1,923
- 5% (2023: - 5%) – ам.доллар	(7,209)	(1,923)
+ 5% (2023: + 5%) – евро	137	1,284
- 5% (2023: - 5%) – евро	(137)	(1,284)

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

б. Хүүгийн түвшний эрсдэл

Хүүгийн түвшний эрсдэл нь зах зээлийн хүүгийн түвшний өөрчлөлт санхүүгийн хэрэгслийн ирээдүйн мөнгөн урсгал эсвэл санхүүгийн байдлын тайлан дахь бодит үнэ цэнэд нөлөөлж болох эрсдэл юм.

Компанид хүүгийн түвшний эрсдэлийг зохицуулах албан ёсны бодлого болон журам байдаггүй учир нь гэвэл Компанийн удирдлага нь ихэнх хүү бодогддог хөрөнгүүд (банкан дахь хугацаат хадгаламжууд) нь тогтмол хүүтэй байдгийг харгалзан энэ эрсдэлээс Компанийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө материаллаг бус гэж үздэг. 2024 оны 12 сарын 31 -ны байдлаар Компанид хүү бодогддог өр төлбөрүүд байхгүй байна.

в. Зах зээлийн үнийн эрсдэл

Үнийн эрсдэл нь санхүүгийн хэрэгсэл, даатгалын гэрээний хөрөнгө ба/эсвэл өр төлбөрийн ирээдүйн мөнгөн гүйлгээний бодит үнэ цэнэ нь зах зээлийн үнийн өөрчлөлтөөс (хүүгийн болон гадаад валютын ханшийн эрсдэл бусад) өөрчлөгдөх эрсдэл юм. Тухайн санхүүгийн хэрэгсэл, гэрээнд хамаарах хүчин зүйлс, эсвэл зах зээл дээр арилжаалагддаг ижил төстэй бүх гэрээ, санхүүгийн хэрэгсэлд нөлөөлж буй хүчин зүйлсээс үүдэлтэй.

Компанийн үнийн эрсдэл нь зах зээлийн үнийн өөрчлөлтийн үр дүнд үнэ цэнэ нь өөрчлөгдөх санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрөөс үүдэлтэй. Компани нь оролцоотой гэрээ байгуулдаггүй тул үнийн эрсдэл үүсэх даатгалын эсвэл давхар даатгалын гэрээ байхгүй.

Компанид томоохон үнийн эрсдэл байхгүй.

27.1.8 Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь системийн доголдол, хувь хүний санамсаргүй болон санаатай үйлдэл болон бусад гадаад хүчин зүйлүүдийн улмаас Компани алдагдалд орж болох эрсдэл юм. Хяналт ажиллахгүй байх үед үйл ажиллагааны эрсдэл нь нэр хүнд унах, хуулийн болон зохицуулалтын асуудалд орох, улмаар санхүүгийн алдагдалд ороход ч хүргэж болно.


Компани хэдийгээр үйл ажиллагааны эрсдэлийг бүрэн арилгах бололцоогүй ч хяналт, мониторинг сайжруулах замаар энэ төрлийн эрсдэлийг удирдаж болно. Хяналтад ажил үүргийн хуваарь, системд нэвтрэх, батлах, тулган баталгаажуулах журмууд, боловсон хүчний боловсрол, тасралтгүй сургалт, үнэлгээний үйл явцууд багтана. Мөн дотоод аудиторын ажлыг ашиглах явдал орно.

28. Болзошгүй өр төлбөр

Хэвийн бизнесийн үйл ажиллагааны явцад Компани нь хууль, эрх зүйн асуудлууд, гомдол нэхэмжлэлд өртөж болно. Ийм хууль, эрх зүйн асуудал, гомдол нэхэмжлэл байгаа бол түүнээс гарах үүрэг хариуцлага нь Компанийн ирээдүйн үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн байдалд их хэмжээний сөрөг үр дагаварыг бий болгохгүй гэж Компанийн удирдлага итгэж байна.

29. Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн хэрэгсэл нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрөөс бүрдэнэ. Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ нь албадан татан буулгахаас бусад тохиолдолд урт хугацааны хэлцэл хийхдээ мэдлэгтэй, хүсэл эрмэлзэлтэй талуудын хооронд энэхүү хэрэгслийг ашиглах юм. Зах зээлийн үнийг ашиглах боломжгүй тохиолдолд тохирох шударга үнэ цэнийг тухайн хөрөнгө эсвэл өр төлбөрийн чанар, хугацаатай харгалзан хөнгөлөлттэй үнээр тооцно.



ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Удирдлагаас гүйцэтгэсэн бодит үнэ цэнийн үнэлгээнд үндэслэн, санхүүгийн байдлын тайлангийн тэдгээр санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн тооцоолсон бодит үнэ цэнэ нь санхүүгийн байдлын тайлан дахь дансны үнэтэй ойролцоо байна.

30. Тайлант хугацааны дараах үйл явдлууд

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн BR 25 / 003 дугаарт тогтоолоороо 2024 оны тайлант жилийн цэвэр ашгийг үндэслэн нэг ширхэг хувьцаа бүрд 67.12 төгрөгийн ногдол ашиг зарласан ба нийт төлөх ногдол ашгийн хэмжээ нь 4,027,200 мянган төгрөг байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолоор Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг баталж, нийтэд мэдээлэхийг зөвшөөрсөн болно.

31. Англи хэл дээрх орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хэл дээрх хувиудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувийг дагана.

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

ХАВСРАЛТ 1

**2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МАЯГТЫН ДАГУУХ ТОЛИЛУУЛГА**

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Даатгалын хураамжийн нийт орлого	28,102,925	16,674,139
Даатгалын хураамжийн буцаалт	(923,803)	(587,385)
Давхар даатгалын хураамжийн зардал	(6,780,379)	(2,861,006)
Даатгалын хураамжийн цэвэр орлого	20,398,743	13,225,748
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	(3,947,814)	(1,927,609)
Хойшлогдсон давхар даатгалын хураамжийн	1,176,076	(1,109,086)
Орлогод тооцсон хураамж	17,627,005	10,189,053
Нийт нөхөн төлбэрийн зардал	(7,549,952)	(4,899,858)
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	1,347,786	579,942
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	34,105	34,399
Нөхөн төлбэрийн цэвэр зардал	(6,168,061)	(4,285,517)
Нөхөн төлбэрийн нөөц сангийн өөрчлөлт	(1,383,324)	1,926,531
Нөхөн төлбэрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	134,201	(408,591)
Уичирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	346,082	(70,884)
Зардалд тооцсон нөхөн төлбөр	(7,071,102)	(2,838,461)
Даатгалын гэрээний зардал	(2,691,881)	(1,524,949)
Давхар даатгалын шимтгэлийн орлого	313,146	287,825
Хөрөнгө оруулалтын олз, гарз	6,722,180	3,720,494
Даатгалын үйл ажиллагааны ашиг / (алдагдал)	14,899,348	9,833,962
Хүү, Эрхийн шимтгэлийн орлого	4,513	2,231
Бусад орлого	15,336	100,236
Еренхий ба удирдлагын зардал	(4,342,263)	(2,972,577)
Борлуулалт, маркетингийн зардал	(2,061,546)	(1,359,986)
Санхүүгийн зардал	(84,247)	(65,254)
Бусад зардал	(568,194)	(37,737)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз / (гарз)	233,089	148,474
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз / (гарз)	(6,635)	603
Бусад ашиг / (алдагдал)	(6,809,947)	(4,090,819)
Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	8,089,401	5,743,143
Орлогын албан татварын зардал	(923,645)	(585,670)
Тайлант жилийн цэвэр ашиг	7,165,756	5,157,473
Бусад дэлгэрэнгүй орлого	(141,900)	1,165,223
Нийт дэлгэрэнгүй орлого	7,023,856	6,322,696

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

ХАВСРАЛТ 2

**2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МАЯГТЫН ДАГУУХ ТОЛИЛУУЛГА**

(Мянган төгрөгөөр)

2024.12.31

2023.12.31

ХӨРӨНГӨ

Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	2,403,666	2,065,454
Ашиглах эрхтэй хөрөнгө	168,408	153,191
Биет бус хөрөнгө	47,813	55,782
	<u>2,619,887</u>	<u>2,274,427</u>
Эргэлтийн хөрөнгө		
Бараа материал	57,372	43,784
Авлага	782,044	572,274
Давхар даатгагчид ногдох даатгалын нөөц сангийн хэсэг	3,109,071	1,798,795
Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо, бусад хөрөнгө	316,215	257,392
Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал	1,563,864	1,089,144
Богино хугацаат хөрөнгө оруулалт	33,912,138	21,381,282
Хугацаат хадгаламж	13,545,086	8,697,693
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	97,918	212,118
	<u>53,383,708</u>	<u>34,052,482</u>
НИЙТ ХӨРӨНГӨ	<u>56,003,595</u>	<u>36,326,909</u>

ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР

Эздийн өмч		
Хувьцаат капитал	6,000,000	5,000,000
Нэмж төлөгдсөн капитал	6,480,250	130,000
Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдэл	(99,483)	42,417
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,122,806	1,122,806
Хуримтлагдсан ашиг	22,376,429	15,210,673
	<u>35,880,002</u>	<u>21,505,896</u>
Богино хугацаат өр төлбөр		
Даатгалын нөөц сангуд	18,221,732	13,206,489
Дансны болон бусад өр төлбөр	1,637,255	1,327,082
Орлогын албан татварын өр төлбөр	127,790	144,337
Түрээсийн өр төлбөр	136,816	143,105
	<u>20,123,593</u>	<u>14,821,013</u>
ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР	<u>56,003,595</u>	<u>36,326,909</u>

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

ХАВСРАЛТ З

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МЯГТЫН ДАГУУХ ТОЛИЛУУЛГА

(Мянган төгрөгөөр)	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц сан	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	Хуримтлагд- сан ашиг	Нийт
2022 оны 12 сарын 31 / 2023 оны 1 сарын 1	5,000,000	130,000	-	-	10,053,200	15,183,200
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	1,122,806	42,417	5,157,473	6,322,696
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
2023 оны 12 сарын 31	5,000,000	130,000	1,122,806	42,417	15,210,673	21,505,896
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	(141,900)	7,165,756	7,023,856
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
Эздийн өмчийн вөрчлөлт	1,000,000	6,350,250	-	-	-	7,350,250
2024 оны 12 сарын 31	6,000,000	6,480,250	1,122,806	(99,483)	22,376,429	35,880,002

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

ХАВСРАЛТ 4

**2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МАЯГТЫН ДАГУУХ ТОЛИЛУУЛГА**

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Даатгалын хураамжийн орлого	27,105,156	16,086,754
Давхар даатгалын нөхөн төлбөр	1,276,355	579,942
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	34,105	34,399
Бусад мөнгөн орлого	252,938	250,941
Мөнгөн орлогын дүн	28,668,554	16,952,036
 Ажиллагчдад төлсөн	2,640,956	2,043,849
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	985,399	675,450
Бараа материал худалдан авахад төлсөн	2,912,865	2,296,189
Ашиглалтын зардалд төлсөн	39,129	59,262
Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж	3,245,286	4,700,066
Нөхөн төлбөрт төлсөн	7,557,366	4,285,517
Үүнээс: Сайн дурын даатгалын	6,130,721	2,932,365
Албан журмын даатгалын	1,426,645	1,353,152
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл	1,359,258	625,371
Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр	1,392,383	1,272,386
Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр	-	12,000
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	37,844	36,254
Татварын байгууллагад төлсөн	1,342,782	604,710
Даатгалын төлбөрт төлсөн	42,272	45,228
Бусад мөнгөн зарлага	908,121	37,736
Мөнгөн зарлагын дүн	22,463,661	16,694,018
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,204,893	258,018
 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	2,012	248,215
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	71,773,586	10,681,969
Хүлээн авсан хүүний орлого	4,668,272	3,624,198
Хүлээн авсан ногдол ашиг	18,015	-
Мөнгөн орлогын дүн	76,461,885	14,554,382
 Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	485,765	190,474
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	89,552,334	16,209,356
Мөнгөн зарлагын дүн	90,038,009	16,399,830
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(13,576,214)	(1,845,448)
 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	7,350,250	-
Мөнгөн орлогын дүн	7,350,250	-
 Санхүүгийн түрээсийн өглөт төлсөн	93,129	80,712
Мөнгөн зарлагын дүн	93,129	80,712
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,257,121	(80,712)
 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр бууралт	114,200	(1,668,142)
 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	212,118	1,880,260
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	97,918	212,118